

Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн

2007 оны хоёрдугаар сарын 13-ний өдрийн 100 дугаар зарлигаар батлав.

## **ЭСТОНИ УЛСЫН НИЙТИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ 1**

2007 оны нэгдүгээр сарын 24-ний өдөр батлав.

### **1-Р БҮЛЭГ**

### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **§ 1. Зорилт**

Энэхүү хуулийн зорилт нь захиалагч байгууллагын санхүүгийн нөөц бололцоог ил тод, зорилго чиглэлтэй, хэмнэлттэйгээр ашиглах, оролцогчдод ижил тэгш хандах, нийтийн худалдан авалт дахь өрсөлдөөнийг үр дүнтэй ашиглахад оршино.

#### **§ 2. Хуулийн үйлчлэх хүрээ**

(1) Энэхүү хуулиар нийтийн худалдан авалтын журам, түүнд оролцож буй субъектуудын эрх үүрэг, энэхүү хуулийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, түүнд төрөөс тавих хяналт, өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх журмыг зохицуулна.

(2) Энэхүү хуулийн зорилгын хүрээнд “нийтийн худалдан авалт” гэдэг нь бараа бүтээгдэхүүн худалдан авах, үйлчилгээ авахаар гэрээ байгуулах, зураг төслийн уралдаан зохион байгуулах, захиалагч байгууллагаас нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулах, ажил үйлчилгээний концесс олгох, концессийг гүйцэтгэгч этгээд ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулахыг ойлгоно.

#### **§ 3. Нийтийн худалдан авалтын ерөнхий зарчим**

Захиалагч байгууллага нийтийн худалдан авалтыг зохион байгуулахдаа дараах зарчмыг мөрдөх үүрэгтэй. Үүнд:

- 1) Захиалагч байгууллага нь санхүүгийн нөөцийг хэмнэлттэй, оновчтойгоор ашиглаж, өрсөлдөөний явцад тендерийн саналуудыг харьцуулах замаар үнэ, чанарын харьцааг хамгийн дээд түвшинд хангах боломжит үнээр нийтийн худалдан авалт хийх зорилтыг биелүүлэх үүрэгтэй.
- 2) Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтын ил тод байдал, хяналт тавих боломжийг хангах үүрэгтэй.

3) Захиалагч байгууллага нь Эстони улс, Европын Холбооны бусад гишүүн улс, Европын эдийн засгийн бүсийн гэрээний гишүүн орон эсхүл ДХБ-ын Засгийн газрын худалдан авалтын тухай гэрээнд нэгдэн орсон улсад оршин суугаа эсхүл тэдгээр улсад байрлаж буй бүх этгээдэд эрх тэгш, ялгаварлалгүйгээр хандаж, нийтийн худалдан авалтын объектын хувьд бүх этгээдэд хязгаарлалт, шалгуурыг тогтоохдоо пропорциональ байдал, ач холбогдол, үндэслэлтэй байдлыг хангах ёстой.

4) Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтад үйлчилж буй өрсөлдөөний нөхцлийг үр нөлөөтэй ашиглах бололцоогоор хангах үүрэгтэй бөгөөд нийтийн эрх зүйгээр зохицуулагдаж буй хуулийн этгээдийн оролцоо эсхүл нийтийн худалдан авалтад нийтийн арга хэрэгслийг ашиглан оролцож буй хувийн эрх зүйгээр зохицуулагдаж буй этгээд нь нийтийн арга хэрэгслийг тийнхүү ашигласнаас үүдэн өрсөлдөөнийг гажуудуулах ёсгүй.

5) Захиалагч байгууллага нь өрсөлдөөнийг гажуудуулах сонирхлын зөрчлөөс зайлсхийх үүрэгтэй.

6) Боломжтой тохиолдолд захиалагч байгууллага нь байгаль орчинд ээлтэй шийдлийг сонгох үүрэгтэй.

#### **§ 4. Нийтийн гэрээ**

(1) Энэхүү хуульд дурдсан “нийтийн гэрээ” хэмээх нэр томъёог нийтийн худалдан авалтын үр дүнд захиалагч нэг буюу хэд хэдэн байгууллага болон нэг буюу хэд хэдэн этгээдийн хооронд материаллаг хамтын үүрэг хариуцлага үүсэх, гэрээний объект нь үйлчилгээ буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил байх гэрээ гэж ойлгоно. Холбогдох гэрээний төрлийн талаарх заалтууд эрх зүйн актуудад заасан нийтийн гэрээнд хэрэглэгдэнэ.

(2) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээг зөвхөн энэ хуульд заасан нөхцлөөр байгуулна. Энэхүү хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан шаардлагыг биелүүлэхгүй байх нь нийтийн гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

(3) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгүүлэх гэрээг дараах ажлыг гүйцэтгүүлэхээр байгуулна. Үүнд:

1) Энэ хуулийн 1 дэх хавсралтад заасан аливаа нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэх эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэх буюу зураг төслийг гаргах,

2) Барилга байгууламж барих, барилга угсралт хийх эсхүл түүний зураг төслийг гаргах,

3) Захиалагч байгууллага үл хөдлөх хөрөнгө буюу түүнтэй холбоотой эрхийг худалдан авах, түрээсээр ашиглах буюу түрээслэхийн өмнө эсхүл эрх зүйн бусад үндэслэлээр захиалагч байгууллагын эзэмшилд өгөх, захиалагч байгууллагаас тодорхой арга, аргачлалд үндэслэн тогтоосон шаардлагын дагуу уг үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх.

(4) Нийтийн нийлүүлэлтийн гэрээ гэдэг нь худалдан авах сонголттой буюу сонголтгүйгээр гэрээний объектыг худалдан авах, түрээсээр ашиглах эсхүл түрээслэх зорилготой гэрээ юм. Түгээх, суурилуулалтын ажлыг багтаасан нийтийн гэрээг мөн нийтийн нийлүүлэлтийн гэрээ гэж үзнэ.

(5) Энэ хуулийн 2 дахь хавсралтад дурдсан үйлчилгээний гэрээг нийтийн үйлчилгээний гэрээгээр байгуулна.

(6) Гэрээний объект нь энэхүү хуулийн 2 дахь хавсралтад дурдсан үйлчилгээг худалдан авах, түүнийг гүйцэтгүүлэх гэрээ байгуулахын аль аль нь байгаа бол нийтийн гэрээ байгуулах үйлчилгээний төсөвт өртөг нь худалдан авах өртгөөс их байх тохиолдолд, уг гэрээг нийтийн үйлчилгээний гэрээ гэж үзнэ. Бусад тохиолдолд энэ нь нийтийн нийлүүлэлтийн гэрээ болно.

(7) Гэрээний объект нь энэхүү хуулийн 2 дахь хавсралтад дурдсан үйлчилгээг худалдан авах, түүнийг гүйцэтгүүлэх гэрээ байгуулахын аль аль нь байгаа бөгөөд 1 дэх хавсралтад дурдсан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулах нь зөвхөн гэрээний ерөнхий объектийн нэмэлт зүйл байх тохиолдолд гэрээг нийлүүлэлтийн эсхүл нийтийн үйлчилгээний гэрээний аль нэг гэж үзнэ.

(8) Захиалагч байгууллага энэхүү нийтийн гэрээний объект болгон гүйцэтгүүлэх шаардлагагүй үйлчилгээ худалдан авах эсхүл түүнийг гүйцэтгүүлэхээр нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээ байгуулахгүй байж болно.

## **§ 5. Нийтийн гэрээний маягт**

(1) НӨАТ тооцоогүй дүнгээр дор хаяж 10,000 евро (Арван мянга)-ны өртөгтэй нийтийн гэрээг бичгээр үйлдэнэ.

(2) Захиалагч байгууллага бүр энэ хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан үнийн дүнгээс бага нийтийн гэрээний маягтад тавигдах шаардлагыг өөрсдөө тогтооно.

(3) Энэ хэсэгт дурдсан маягтыг баримтлахгүй байх нь нийтийн гэрээний хүчин төгөлдөр байх эсэхэд нөлөөлөхгүй.

## **§ 6. Концесс**

(1) Энэхүү хуульд заасан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгүүлэх концесс гэдэг нь энэ хуулийн 4(3) хэсэгт дурдсан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгүүлэх гэрээнд заасантай адил зүйлийг тусгасан, ажил гүйцэтгэх концессийн гэрээ байгуулсан этгээдийн эрх эсхүл захиалагч байгууллагын мөнгөн төлбөр төлөх эрхийн талаарх мөн зүйлд дурдсан ажлын төлбөрийн дагуу байгуулсан гэрээ юм.

(2) Энэхүү хуульд зааснаар үйлчилгээний концесс гэдэг нь энэ хуулийн 2-р хавсралтад дурдсан үйлчилгээний гэрээнд заасантай адил зүйлийг тусгасан, тодорхой үйлчилгээ үзүүлж, энэ үйлчилгээний хэрэглэгчдээс үйлчилгээ үзүүлсний төлбөр хүлээн авах концессийн гэрээ байгуулсан этгээдийн эрх, тэр дундаа захиалагч байгууллагаас төлөх мөнгөн төлбөрийн талаар байгуулсан гэрээ юм.

## **§ 7. Ерөнхий гэрээ**

(1) Энэхүү хуульд дурдсан “Ерөнхий гэрээ” гэдэг нь гэрээ байгуулах эрх бүхий нэг буюу түүнээс дээш байгууллага болон нэг буюу хэд хэдэн этгээдийн хооронд байгуулагдсан бөгөөд гэрээний хүчинтэй хугацаанд гэрээнд үйлчлэх нөхцөл, нэн ялангуяа гэрээний үнэ, үнэ ба тоо, эсхүл хэмжээтэй холбоотой нөхцлийг заасан гэрээ байна.

(2) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нийтийн гэрээний нөхцлийг ерөнхий гэрээнд хэрэглэнэ.

## **§ 8. Динамик худалдан авалтын систем**

(1) Энэ хуульд заасан “динамик худалдан авалтын систем” гэдэг нь шаардлага хангасан бөгөөд захиалагч байгууллагын боловсруулсан техникийн тодорхойлолтод нийцсэн индикатив тендерийн санал ирүүлсэн бүх сонирхогч этгээд нэгдэн орж, захиалагч байгууллага хялбарчилсан журмын дагуу ашиглах хугацааны туршид динамик худалдан авалтын системд бүртгүүлсэн тендерийн оролцогчидтой нийтийн гэрээ байгуулах бололмжтой нийтийн гэрээ байгуулах электрон процесс юм.

(3) Илүү урт хугацааны бодит шаардлага байхгүй бөгөөд динамик худалдан авалтын системийн зүйлээр нотлогдсон тохиолдолд захиалагч байгууллага нь динамик худалдан авалтын системийг 4 хүртэл жилийн хугацаатай байгуулж болно. Захиалагч

байгууллага нь динамик худалдан авалтын систем үүсгэх, түүнд үндэслэн нийтийн гэрээ байгуулах тухай энэ хуулийн 58 (2-3)-ын дэд хэсгийг мөрдөнө.

(3) Динамик худалдан авалтын системийг үүсгэж, хэрэглэх болон энэ системд үндэслэн нийтийн гэрээ байгуулах нөхцөл, журмыг Бүгд найрамдах Эстони улсын Засгийн газраас тогтооно.

(4) Энэ хуульд заасан “индикатив тендерийн санал” гэдэг нь захиалагч байгууллагын бэлтгэсэн техникийн тодорхойлолд нийцсэн динамик худалдан авалтын системд нэгдэн орох зорилготой этгээдийн хүсэлтийг илэрхийлж буй хэлбэр юм. Индикатив тендерийн санал нь нийтийн гэрээ байгуулах хүсэлт илэрхийлж буй хэлбэр биш болно.

### **§ 9. Зураг төслийн уралдаан**

(1) Энэ хуульд заасан “зураг төслийн уралдаан” гэдэг нь төлөвлөлт, архитектур, инженерийн ажил, мэдээллийн систем, программ хангамж эсхүл өгөгдөл боловсруулах салбарт өрсөлдөөний явцад шүүгчдийн сонгосон төлөвлөгөө буюу зураг төслийг сонгон авах боломжоор захиалагч байгууллагыг хангах ажиллагаа юм.

(2) Зураг төслийн уралдааныг түүний ялагчтай нийтийн үйлчилгээний гэрээ байгуулах зорилгоор эсхүл ялагчдад нь шагнал олгох эсхүл зөвхөн оролцогчдод нь оролцсон урамшуулал өгөх замаар захиалагч байгууллагад тохирох зураг төслийн шийдлийг олох зорилгоор зохион байгуулж болно.

### **§ 10. Захиалагч байгууллага**

(1) Энэхүү хуульд заасан журмыг дараахи этгээд, байгууллага (цаашид *Захиалагч байгууллага* гэх) мөрдлөгө болгоно:

1) Төр буюу төрийн байгууллага

2) Орон нутгийн засаг захиргааны байгууллага, түүний харьяа байгууллага буюу нийгэмлэг холбоо

3) нийтийн эрх зүйгээр зохицуулагддаг бусад хуулийн этгээд эсхүл нийтийн эрх зүйгээр зохицуулагддаг хуулийн этгээд

4) Дор хаяж үүсгэн байгуулагчдын нэг нь төр байх эсхүл үүсгэн байгуулагчдын талаас илүү нь дэд хэсгийн 2 буюу 3-р зүйлд заасан этгээд эсхүл тэдгээрийн талаас илүү нь 1-3-р зүйлд заасан этгээдүүдийн томилдог хяналтын зөвлөлийн гишүүд байх,

5) Гишүүдийнх нь талаас илүү хувь нь энэ дэд хэсгийн 1-3 зүйлд заасан этгээд байх ашгийн бус холбоо нийгэмлэг

б) Энэ хэсгийн 2-р дэд хэсэгт заасан шинж чанарт нийцэх бусад хувийн эрх зүйн хуулийн этгээд.

(2) Захиалагч байгууллагын талаар энэ хэсгийн 1 (б) дурдсан хувийн эрх зүйн хуулийн этгээд гэдэг нь:

1) нийтийн ашиг сонирхлын үүднээс үүсгэн байгуулагдсан эсхүл энэ зорилгоор үйл ажиллагаа явуулж буй, үйлдвэрлэлийн буюу арилжааны чанар агуулаагүй

2) Удирдах зөвлөл, захиргааны нэгж эсхүл хяналтын зөвлөлийн гишүүдийн талаас илүү хувийг 1-р дэд хэсгийн б) буюу 1)-ээс 5)-г заасан бусад этгээд эсхүл Европын эдийн засгийн бүсийн гэрээнд нэгдсэн бусад орны холбогдох этгээд томилдог эсхүл түүний удирдлагыг хамтдаа буюу дангаар хянадаг,

(3) энэхүү хуульд заасны дагуу, 83-аас 89-р хэсэгт дурдсан үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулах захиалагч байгууллагад дараахи байгууллага хамаарна:

1) 83-аас 89 хэсэгт дурдсан үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа явуулах тусгай эсхүл цор ганц эрх бүхий этгээд,

2) энэ хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан этгээдүүд буюу тэдгээр этгээд нь Европын Холбооны бусад гишүүн улсын холбогдох этгээдтэй хамтран хувьцааны талаас илүү хувийг эсхүл санал өгөх эрхтэй хувьцааны талаас илүүг хувийг нь эзэмшдэг эсхүл удирдлагын буюу хяналтын зөвлөлийн талаас илүү хувийг нь шууд буюу шууд бусаар томилдог компани.

(4) Энэ хэсгийн 1-р дэд хэсгийн 6-д дурдсан этгээдийн үүсгэн байгуулагч нь тухайн этгээдийн статусыг үүсгэн байгуулагчийн тухай 2-р дэд хэсэгт заасан шинж чанарт нийцүүлэн тодорхойлох бөгөөд тухайн этгээд өөрөө нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх даалгавар хүлээн авахдаа холбогдох статусаа тодорхойлно. 2-р дэд хэсэгт заасан хэлбэрээр статусаа өөрчлөх тохиолдолд Нийтийн худалдан авалтын газарт энэ талаараа нэн даруй мэдэгдэнэ.

## **§ 11. Захиалагч байгууллагын санхүүжүүлсэн ажил, бусад этгээдээс захиалагч байгууллагад өгсөн үл хөдлөх хөрөнгийн ажилд гэрээ байгуулах**

(1) Энэхүү хуулийн 10-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан захиалагч этгээдийн тухайд энэхүү хуулийн зүйл заалтыг тэдгээр этгээдээс 50-аас дээш хувь санхүүжүүлж буй ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа хүн бүр дагаж мөрдөнө.

1) Энэ хуулийн хавсралт 1-ийн 45.21-т заасан инженер техникийн байгууламж буюу барилга, эмнэлэгийн буюу боловсролын барилга байгууламжийн ажил, засаг захиргааны барилга буюу спорт, амралт зугаалга буюу чөлөөт цаг өнгөрөөх байгууламжийн ажил болон ажлын гэрээний тухайд, эдгээр ажлын НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын үнийн доод хязгаарт хүрсэн буюу түүнээс их байх эсхүл

2) Энэхүү дэд хэсгийн 1-д заасан ажилтай холбоотой үйлчилгээ болон эдгээр үйлчилгээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын үнийн доод хязгаарт хүрсэн буюу түүнээс их байх тохиолдолд.

3) Ажлын гэрээ байгуулахдаа үл хөдлөх хөрөнгийг хүлээлгэн өгөхтэй холбоотой үүсэх үүрэг хариуцлага, захиалагч байгууллагад холбогдох эрх буюу бусад үл хөдлөх хөрөнгийг ашиглахтай холбоотой үүсэх бусад үүрэг хариуцлагаа биелүүлүүлэхийн тулд энэ хуулийн 4 хэсгийн 3.3-т заасан ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулж буй этгээд бүр захиалагч байгууллагын тухайд энэ хуулийн дэд хэсгийг мөрдөх үүрэгтэй.

## **§ 12. Тендерт оролцогч ба өрсөлдөгч**

(1) Энэ хуульд зааснаар тендерт оролцогч гэдэг нь худалдан авах үйл явцад тендерийн санал өгсөн эсхүл динамик худалдан авалтын системд индикатив тендерийн санал ирүүлсэн этгээд юм.

(2) Энэ хуульд зааснаар өрсөлдөгч гэдэг нь хязгаарлагдмал журам буюу гэрээний мэдэгдэл эсхүл өрсөлдөөнт хэлцлийн тухай урьдчилан нийтлэсэн тохиролцсон журам байгаа тохиолдолд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан этгээд юм.

(4) Тендерт оролцогч буюу өрсөлдөгч нь зах зээл дээр бараа бүтээгдэхүүн санал болгох, үйлчилгээ үзүүлэх эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх ямар ч этгээд байж болно. Захиалагч байгууллага нь энэ хуулийн 3-р зүйлийн 3-р хэсэгт зааснаас бусад орны этгээдүүдийг худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байхаар худалдан авах ажиллагааны тендерт оролцогч, өрсөлдөгчдийн хүрээг гэрээний мэдэгдэлд дурдах замаар хязгаарлах эсхүл бусад орны этгээдүүд тендерийн санал ирүүлэхээс өмнө 3-р зүйлийн 3-р хэсэгт заасан орнуудын этгээдүүдийн ирүүлсэн тендерийн саналд давуу тал олгож болно.

(5) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол тухайн этгээдүүд нь тендерийн санал, индикатив тендерийн санал эсхүл худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ хамтран гаргаж болно (цаашид *хамтран тендерт оролцогч, хамтран өрсөлдөгч* гэх).

(5) Хамтран тендерт оролцогчид эсхүл хамтран өрсөлдөгчид нь худалдан авалтын журам, нийтийн гэрээ байгуулах, түүнийг гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий төлөөлөгчийг томилно.

(6) Захиалагч байгууллага хамтарсан тендер буюу хамтарсан худалдан авалтад оролцох хүсэлтийг хүлээж авахдаа тендерт хамтран оролцогчид буюу хамтран өрсөлдөгчдийг хуулийн этгээд байгуулах эсхүл хуулийн бусад хэлбэрээр нэгдэхийг урьдач нөхцөл болгон шаардахгүй байж болно. Хамтран тендерт оролцогчдын хоорондох эрх зүйн харилцааг тодорхой арга, хүрээнд зааж өгөх нь нийтийн гэрээний объектын онцлогт үндэслэн нийтийн гэрээг зохих ёсоор хэрэгжүүлэхэд шаардлагатай бол захиалагч байгууллага нь нийтийн гэрээг биелүүлэх хугацааг холбогдох байдлаар нарийвчлан заахыг шаардаж болно.

(7) Энэ хуульд зааснаар тендерт оролцогч буюу өрсөлдөгчтэй холбоотой компани гэдэг нь тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн шууд буюу шууд бус давуу нөлөөнд байх аливаа компани эсхүл тендерт оролцогч буюу өрсөлдөгчид давуу нөлөө үзүүлж болох компани эсхүл эзэмшил, санхүүгийн оролцоо, эрх зүйн акт буюу бусад үндэслэлийн дагуу гуравдагч этгээдийн давамгай нөлөөнд байх компани юм.

Өөр компанитай шууд буюу шууд бусаар харилцах үед бусад компанийн хөрөнгийн талаас илүү хувийг эзэмшдэг эсхүл хувьцаанд ногдох санал өгөх эрхийн дийлэнхи хэсгийг хянадаг эсхүл бусад компанийн удирдлагын буюу хяналтын нэгжийн гишүүдийн талаас илүү хувийг нь томилдог тохиолдолд тухайн компанийн хувьд давамгайлах нөлөө байна гэж үзнэ.

### **§ 13. Нийтийн худалдан авалтыг зохион байгуулахад хамтран ажиллах, бусдад эрх олгох**

(1) Захиалагч байгууллагууд нь нийтийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аль нэг захиалагч байгууллагад олгох замаар нийтийн худалдан авалтыг хамтран зохион байгуулж болно. Нийтийн худалдан авах ажиллагааг хамтран зохион байгуулахдаа захиалагч байгууллагууд нь энэ хуулийн дагуу нийтийн худалдан авах ажиллагааг дангаар зохион байгуулахад мөрдөх ёстой дүрэм журмыг мөрдөх үүрэгтэй. Нийтийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа нийтийн гэрээний нийт тооцоолсон үнийн дүнд үндэслэн дүрэм журмыг хэрэглэнэ.



(2) Захиалагч байгууллага нь бусад захиалагч байгууллагад энэ хуулийн дагуу нийтийн худалдан авалтыг зохион байгуулахтай холбогдон үүсэх бүх үүрэг хариуцлагыг биелүүлэх зөвшөөрөл олгох эрхтэй.

(3) Захиалагч байгууллага нь худалдан авах журамтай холбоотой үйл ажиллагааг бусад этгээдээр гүйцэтгүүлэх эрхтэй.

#### **§ 14. Журамд үл хамаарах зүйлс**

(1) Захиалагч байгууллага нь дараахи тохиолдолд энэ хуульд заасан журмыг заавал мөрдөх үүрэг хүлээхгүй. Үүнд:

1) бараа бүтээгдэхүүн худалдан авах, үйлчилгээний эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээ байгуулах, ажлын концесс олгох, Электрон харилцаа холбооны хуульд заасны дагуу олон нийтэд зориулан электрон харилцаа холбооны сүлжээ санал болгох буюу ажиллуулах эсхүл олон нийтэд электрон харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх зорилгоор зураг төслийн уралдаан зохион байгуулах,

2) Байгуулах гэрээ эсхүл зохион байгуулах зураг төслийн уралдаан нь Төрийн нууцын тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах, гадаад улсын нууц мэдээлэл, аюулгүй байдлын мэдээлэл эсхүл нийтэд зарлаж болохгүй мэдээлэл, эсхүл гэрээг биелүүлэхийн тулд хуульд заасны дагуу аюулгүй байдлын тусгай шаардлагыг биелүүлэх шаардлагатай, эсхүл төрийн чухал ашиг сонирхлыг хамгаалахын тулд дүрэм журмыг дагах шаардлагагүй тохиолдолд,

3) Эстони ба гадаадын зарим улсын (Европын Холбооны гишүүн улсуудыг оролцуулалгүйгээр) хооронд Европын Хамтын Нийгэмлэгийг байгуулсан гэрээнд нийцүүлэн байгуулсан олон улсын гэрээнд заасан журмын дагуу бараа бүтээгдэхүүн худалдан авах эсхүл ажлын концесийн гэрээ байгуулах, тэдгээр бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээ байгуулах эсхүл ажлын концесс олгох зорилго нь Эстони болон гадаад улс хамтран нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх эсхүл барилга байгууламжийг хамтран ашиглахад орших тохиолдолд эсхүл олон улсын гэрээнээс үүдсэн журмын дагуу үйлчилгээний гэрээ байгуулах буюу зураг төслийн уралдаан зохион байгуулах эсхүл эдгээр үйлчилгээний гэрээ байгуулах, зураг төслийн уралдаан зохион байгуулах зорилго нь Эстони болон гадаад орны хамтарсан төслийг хэрэглэх буюу ашиглах тохиолдолд,

- 4) Цэрэг армийн нэгжийн байрлалтай холбоотой олон улсын гэрээнд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох эсхүл зураг төслийн уралдааныг зохион байгуулах бол,
  - 5) олон улсын байгууллагын тусгай журмыг үндэслэн гэрээ байгуулах эсхүл зураг төслийн уралдаан зохион байгуулах,
  - 6) Гэрээний төрлийг үл харгалзан, үл хөдлөх хөрөнгө буюу түүнтэй холбоотой эрхийг худалдан авах, түрээсээр ашиглах эсхүл түрээслэх,
  - 7) Радио, телевизийн хөтөлбөр буюу түүний хэсгийг худалдан авах, боловсруулах, бүтээх буюу хамтран бүтээх зорилгоор радио, телевизийн байгууллага нь үйлчилгээний гэрээ байгуулах, нэвтрүүлэх цагтай холбоотой гэрээ байгуулах,
  - 8) Арбитрын эсхүл эвлэрүүлэх үйлчилгээний гэрээ байгуулах,
  - 9) Үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслүүд, түүний дотор Эстонийн Төв банкны мөнгө, капиталын оролцоо болон үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой үйлчилгээг зах зээлд гаргах, худалдан авах, борлуулах эсхүл эрх шилжүүлэх,
  - 10) хөдөлмөрийн гэрээ байгуулах,
  - 11) судалгаа, боловсруулалтын гэрээ байгуулах,
  - 12) Европын Хамтын нийгэмлэгийг байгуулсан гэрээний шаардлагад нийцүүлсэн эрх зүйн актуудын үндсэн дээр олгогдсон тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчилгээ явуулах цорын ганц эрхийг эзэмшдэг өөр захиалагч байгууллага эсхүл захиалагч байгууллагуудын нийгэмлэгээс үйлчилгээ авахаар гэрээ байгуулах
  - 13) Хувьцаа нь бүхэлдээ буюу түүний хэсэг нь захиалагч байгууллагад эсхүл бусад захиалагч байгууллагууд буюу сангуудад хамаарах, компанийн цорын ганц үүсгэн байгуулагч тухайн захиалагч байгууллага байх эсхүл бүх үүсгэн байгуулагч нь тухайн захиалагч байгууллага нь бусад захиалагч байгууллагуудын хамт байх эсхүл үйл ажиллагааны гол хэсэг нь захиалагч байгууллагууд хувь эзэмшигч буюу үндэслэгч нь байх компанид худалдах, үйлчилгээ нийлүүлэх эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, энэ компани буюу сан нь захиалагч байгууллагад эд зүйл эсхүл түүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай арга хэрэгсэл нийлүүлсэн бол энэ хуулийн үндэслэлээр захиалагч байгууллагад нийлүүлэх журмаар үйлчилгээ үзүүлэх эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх,
- (2) Захиалагч байгууллага нь энэ хэсгийн (1)-ийн 3)-т заасан олон улсын гэрээ байгуулсан тухайгаа Сангийн ямаар дамжуулан Европын Комисст бичгээр мэдэгдэнэ.

(3) Үл хөдлөх хөрөнгө эсхүл түүнтэй холбоотой эрхийг худалдан авах, түрээсээр ашиглах буюу түрээслэхтэй холбогдсон санхүүгийн үйлчилгээний гэрээ байгуулах нь энэ хэсгийн (1)-ийн б)-д дурдсан журамд үл хамаарах зүйлст хамаарахгүй.

(4) Зөвхөн захиалагч байгууллага энэхүү судалгаанаас ашиг олох бөгөөд гэрээт үйлчилгээний хөлсийг бүрэн төлж буй тохиолдолд энэ хэсгийн (1)-ийн 11)-д дурдсан журамд үл хамаарах зүйлст хамаарахгүй.

(5) Захиалагч байгууллага нь энэ хуулийн (1)-д заасан үндэсний батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бол батлан хамгаалах зорилготой гэрээ байгуулах тохиолдолд энэ хуульд заасан журмыг Европын хамтын нийгэмлэгийг байгуулсан гэрээний 296 зүйл болон түүний үндсэн дээр батлагдсан эрх зүйн актуудын тогтоосон хүрээнд хэрэглэнэ.

### **§ 15. Босго үнэ**

(1) Энэхүү хуульд зааснаар нийтийн худалдан авалт зохион байгуулах, ажил гүйцэтгүүлэх концесс олгох, зураг төслийн уралдаан зохион байгуулах өртгийн босго үнэ (цаашид *нийтийн худалдан авалтын босго үнэ* гэх) нь дараахи хэмжээтэй байна. Үүнд:

1) 2007 онд эхэлсэн нийтийн худалдан авалтын тухайд үйлчилгээний гэрээ, зураг төслийн уралдааны хувьд 30 мянган евро, нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээ, ажлын концессийн хувьд 190 мянган евро,

2) 2008 онд болон түүнээс хойш эхэлсэн нийтийн худалдан авалтын тухайд үйлчилгээний гэрээ, зураг төслийн уралдааны хувьд 40 мянган евро, нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх гэрээ, ажлын концессийн хувьд 250 мянган евро,

(2) Ус, эрчим хүч, тээвэр, шуудангийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй худалдан авагчийн худалдан авах журмыг (ОJ L 134, 2004 оны 4-р сарын 30, хуудас 1-113) уялдуулан зохицуулсан Европын Парламент ба Зөвлөлийн 2004/17 тоот удирдамжийн 69-р хэсэг болон ажил гүйцэтгүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох журмыг уялдуулан зохицуулах тухай Европын Парламент ба Зөвлөлийн 2004/18 тоот удирдамжийн 78-р хэсэгт үндэслэн Европын комисс нь олон улсын босго үнийг тогтмол хугацаанд тогтоож, Европын Холбооны албан ёсны сэтгүүлд хэвлүүлнэ.

Мөн олон улсын босго үнийг Нийтийн худалдан авалтын газар (цаашид *газар* гэх) цахим хуудас болон Нийтийн худалдан авалтын улсын бүртгэлийн газрын (цаашид *бүртгэлийн газар* гэх) холбогдох цахим хуудсаар дамжуулан нийгэд зарлаж болно.

### **§ 16. Нийтийн гэрээ байгуулах эрх олгоход баримтлах журам**

(1) 10 хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нийтийн худалдан авалтын босго үнээс бага байх тохиолдолд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа энэ хуульд заасан худалдан авах журмыг баримтлахгүй байж болно.

Энэ тохиолдолд захиалагч байгууллага нь нийтийн гэрээ байгуулах эрх олгох тухай энэ бүлэгт заасан шаардлага, 3-р хэсэгт заасан нийтийн худалдан авалт зохион байгуулах ерөнхий зарчим, 37-р хэсгийн 2-р дэд хэсэгт заасан нийтийн худалдан авалтын тайлан гаргах шаардлагыг тус тус мөрдөнө.

(2) Нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нийтийн худалдан авалтын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс өндөр тохиолдолд 10-р хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь гэрээ байгуулах эрх олгох тухай 2-р бүлгийн журмыг баримтална.

(3) 10-р хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь нийтийн гэрээ байгуулах эрх олгохдоо түүний гол зорилго нь 83-аас 89 хэсэгт заасан салбарт үндсэн үйл ажиллагаа нь хамаарах бөгөөд нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс өндөр тохиолдолд нийтийн гэрээ байгуулах эрх олгох тухай 2-р бүлэгт заасан журмын оронд 5-р бүлэгт заасан журмыг баримталж болно.

(4) Нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг олон улсын босго үнээс бага байх тохиолдолд энэ хуулийн 10 хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллагыг энэ хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагаа явуулахыг хориглоно. Энэ тохиолдолд захиалагч байгууллага нь энэ бүлэгт заасан шаардлагууд болон 3-р хэсэгт заасан худалдан авалт зохион байгуулах ерөнхий зарчмуудыг мөрдөнө.

(5) 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь нийтийн гэрээ байгуулах эрх олгохдоо түүний зорилго нь 83-89-р хэсэгт заасан салбарт үндсэн үйл ажиллагаа нь хамаарах, нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нь олон улсын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс өндөр байх тохиолдолд 5-р бүлэгт заасан журмыг баримтална. 83-89-р хэсэгт заасан салбарт үйл ажиллагаа нь хамаарах тохиолдолд дээр дурдсан үүрэг хариуцлага хүчин төгөлдөр байх боловч нийтийн гэрээний үндсэн зорилгыг тодорхойлох боломжгүй байж болно.

(6) Захиалагч байгууллага нь энэ хуулийн 10-р хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан байгууллагуудын нэг байх тохиолдолд төсөвт өртгийн НӨАТ тооцоогүй дүн нь бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний тухайд 20 мянган евро эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын тухайд 130 мянга еврогоос их байх эсхүл захиалагч байгууллага нь энэ хуулийн 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан байгууллагуудын нэг байх тохиолдолд бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний тухайд 40 мянган евро эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын тухайд 250 мянга еврогоос их боловч худалдан авалт зохион байгуулах үүрэгтэй холбогдох захиалагч байгууллагын босго үнээс бага байх нийтийн гэрээ байгуулах эрх олгох хүсэлтийг цахим хуудсаар эсхүл цахим хуудас байхгүй тохиолдолд орон нутгийн сонингоор мэдээлнэ.

(7) Энэ хуулийн 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь НӨАТ тооцоогүй өртөг нь бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний тухайд 40 мянган евро эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын тухайд 250 мянган еврогоос их боловч олон улсын босго үнээс бага байх тохиолдолд нийтийн гэрээний эрх олгосныг нийтийн гэрээ байгуулах эрх олгох журмын дагуу 10 хоногийн хугацаанд цахим хуудсаар мэдэгдэнэ.

(8) Захиалагч байгууллага нь энэ хэсгийн 6 буюу 7-р дэд хэсэгт заасан нийтийн худалдан авалтын босго үнэ, олон улсын босго үнэ эсхүл санхүүгийн үнэлгээ болон нийтийн гэрээний шинж чанар нь нийтийн гэрээ байгуулах эрх олгохтой хамаатай, төсөвт өртөг нь холбогдох санхүүгийн үнэлгээнд хүрээгүй эсхүл шинж чанараас нь хамааран энэ журамд нийцэхгүйгээс үүсэх заавал биелүүлэх журмыг баримтлах эрхтэй.

(9) Захиалагч байгууллага нь хууль тогтоомжийн дагуу үүсэх холбогдох үүрэг хариуцлагыг хүлээхгүйгээр худалдан авах ажиллагааг эхлүүлсэн тохиолдолд энэ хуульд заасан холбогдох худалдан авах журмыг баримтлах үүрэгтэй.

## **§ 17. Концесс олгоход баримтлах журам**

(1) Энэ хуулийн 10-р хэсгийн 1-р дэд хэсэгт заасан захиалагч байгууллага нь ажлын концессээр хийгдэх нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан тохиолдолд ажлын концессийн тухай 3-р бүлэгт заасан журмыг баримтална.

(2) 83-аас 89 хэсэгт заасан салбарт үйл ажиллагаа нь хамаарах ажлын концесс олгох үед эсхүл ажлын концессоор хийгдэх нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төсөвт

өртөг нь нийтийн худалдан авалтын босго үнээс бага байх тохиолдолд 10-р хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь энэ хуульд заасан ажлын концесс олгох журмыг мөрдөх үүрэг хүлээхгүй бөгөөд ажлын концесс олгох тухай энэ бүлэгт заасан шаардлага болон 3-р хэсэгт заасан нийтийн худалдан авалт зохион байгуулах ерөнхий зарчмыг мөрдөнө.

(3) Энэ хуулийн 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь энэ хуульд заасан ажлын концесс олгох журмыг мөрдөх үүрэг хүлээхгүй бөгөөд ажлын концесс олгох тухай энэ бүлэгт заасан шаардлага болон 3-р хэсэгт заасан нийтийн худалдан авалт зохион байгуулах ерөнхий зарчмыг мөрдөнө.

(4) Захиалагч байгууллага нь үйлчилгээний концесс олгохдоо зөвхөн энэ бүлэгт заасан шаардлага болон 3-р хэсэгт заасан нийтийн худалдан авалт зохион байгуулах ерөнхий зарчмыг мөрдөнө.

#### **§ 18. Зураг төслийн уралдааныг зохион байгуулахад баримтлах журам**

(1) Энэ хуулийн 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь зураг төслийн уралдааны төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс их байх тохиолдолд зураг төслийн уралдаан зохион байгуулах тухай 4-р бүлэгт заасан журмыг баримтална.

(2) Энэхүү хуулийн 10-р хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан захиалагч байгууллага нь 83-аас 89 хэсэгт заасан салбарт үйл ажиллагаа нь хамаарах зураг төслийн уралдаан зохион байгуулах, түүний төсөвт өртөг нь олон улсын босго үнэд нь хүрсэн эсхүл түүнээс их байх тохиолдолд зураг төслийн уралдаан зохион байгуулах тухай 4-р бүлэгт заасан журмыг баримтална.

#### **§ 19. Хялбарчилсан журмаар байгуулах үйлчилгээний гэрээ**

(1) Захиалагч байгууллага нь энэ хуулийн 2-р хавсралтын Б хэсэгт дурдсан үйлчилгээний төсөвт өртөг нь 50 хувиас илүү байх үйлчилгээний гэрээ байгуулахдаа энэ хуульд заасан үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох тухай журмыг баримтлан худалдан авах ажиллагаа явуулах үүрэг хүлээхгүй.

(2) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээний объект болох тэдгээр үйлчилгээ болон 2-р хавсралтын А хэсэгт дурдсан үйлчилгээ, 2-р хавсралтын Б хэсэгт дурдсан үйлчилгээний төсөвт өртөг эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг нь нийтийн худалдан авах босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан тохиолдолд энэ хэсгийн

1-р дэд хэсгийн заалтыг үл харгалзан худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй.

(2) Энэ хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй өртөг нь нийтийн худалдан авах босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан бол Захиалагч байгууллага нь энэ хуулийн 37-рт заасан журмын дагуу нийтийн гэрээ байгуулах эрх олгосныхоо дараа нийтийн худалдан авах ажиллагааны тайланг гаргана.

Ийм төрлийн нийтийн гэрээний НӨАТ тооцоогүй төсөвт өртөг нь олон улсын босго үнэд хүрсэн буюу түүнээс давсан бол захиалагч байгууллага нь 33-рт заасан техникийн тодорхойлолтыг боловсруулах журмыг баримтлах үүрэгтэй. Бусад тохиолдолд захиалагч байгууллага нь ийм төрлийн нийтийн гэрээ байгуулах тухай зөвхөн энэ бүлэгт заасан шаардлага болон 3-рт заасан нийтийн худалдан авалт явуулах үндсэн зарчмыг мөрдөнө.

## **§ 20. Нийтийн худалдан авалтын өртгийг тооцоолох дүрэм**

(1) Нийтийн худалдан авалтын төсөвт өртгийг НӨАТ-гүйгээр дараах байдлаар тооцно. Үүнд:

1) Нийтийн гэрээ болон түүнийг шинэчлэн байгуулахтай холбоотойгоор ирээдүйд үүсч болох үүрэг хариуцлагыг тооцсоны үндсэн дээр захиалагч байгууллагаас нийтийн гэрээг хэрэгжүүлэхэд төлөх нийт дүн,

2) Зураг төслийн уралдаанд олгох боломжит шагнал буюу оролцсоны урамшуулал,

3) Ажлын концессиор хэрэгжүүлж буй нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын нийт төсөвт өртөг,

(2) Нийтийн худалдан авалтын нийт төсөвт өртгийг тооцохдоо худалдан авах ажиллагааны тухай олон нийтэд мэдэгдэх, зураг төслийн уралдаан эхлэх эсхүл ажлыг концессийн бүртгэлд бүртгэх үеийн зах зээлийн дундаж үнэтэй уялдуулан тогтоох ёстой.

(3) Нийтийн гэрээний НӨАТ ороогүй нийт төсөвт өртгийн хамгийн дээд хязгаарыг тогтоохдоо Ерөнхий гэрээ эсхүл динамик худалдан авалтын системийн хүчинтэй хугацаанд Ерөнхий гэрээ эсхүл динамик худалдан авалтын системийн төсөвт өртөгт үндэслэн нийтийн гэрээнүүдийн төсөвт өртгийг тооцно.

(4) Нээлттэй эсхүл хязгаарлагдмал журмаар шинэ ажил эсхүл үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох боломжтой тохиолдолд энэ хуулийн 28-р зүйлийн (5)-ийн 2)-т заасан журмын дагуу гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмаар явуулах худалдан авалтын мэдэгдэлд тусгасан бол ийм төрлийн нийтийн нэмэлт гэрээнд

үндэслэн гэрээ байгуулсан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил эсхүл үйлчилгээний төсөвт өртгийг нийтийн гэрээний төсөвт өртөгт багтаан тооцно.

(5) Захиалагч байгууллага зураг төслийн уралдааны дүнд үндэслэн үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгохгүй тохиолдолд зураг төслийн уралдааны төсөвт өртөг нь шагнал эсхүл оролцсон урамшууллын нийлбэр дүн, түүний дотор үйлчилгээний гэрээ байгуулах байсан нийт төсөвт өртгөөс бүрдэнэ.

(6) Нийтийн худалдан авалт хийхдээ тогтоосон журам эсхүл шаардлагыг мөрдөхөөс зайлсхийх зорилгоор нийтийн худалдан авалтын төсөвт өртгийг тооцох үндэслэлийг ашиглаж болохгүй. Нийтийн худалдан авалтын төсөвт өртгийг энэ бүлэгт дурдсан заалтуудаас үүдэн хэд хэдэн аргачлалаар тооцох боломжтой, тэдгээр аргачлалаас дор хаяж нэгийг нь ашигласнаар нийтийн худалдан авалтын төсөвт өртөг нь нийтийн худалдан авалтын эсхүл олон улсын босго үнэд хүрэх эсхүл холбогдох босго үнээс хэтэрсэн бол захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтын төсөвт өртгийг энэ аргачлалын үндэслэлд тулгуурлан тооцон гаргах үүрэгтэй.

(7) Захиалагч байгууллага нийтийн худалдан авалтын оролцогчдод энэ хуульд заасан оролцооны зардлыг хаах зорилгоор оролцооны хураамж төлөх бол оролцсон урамшууллыг нийтийн худалдан авалтын төсөвт өртөгт багтаан тооцно.

## **§ 21. Нийтийн нийлүүлэлт эсхүл нийтийн үйлчилгээний гэрээний төсөвт өртгийг тооцох**

(1) Бараа бүтээгдэхүүнийг түрээсээр ашиглах эсхүл түрээслэх нийтийн нийлүүлэлтийн гэрээний төсөвт өртөг нь дараахи зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

1) Тогтоосон хугацаатай нийтийн гэрээний тухайд нийтийн гэрээний хугацаа нь 12 сар буюу түүнээс бага бол нийтийн гэрээний хүчинтэй хугацаан дахь түүний нийт төсөвт өртөг,

2) Тогтоосон хугацаатай нийтийн гэрээний тухайд нийтийн гэрээний хугацаа 12 сар буюу түүнээс урт бол нийтийн гэрээний хугацаа дуусах хүртэлх гэрээний объектын үлдэгдэл өртөг бүхий нийтийн гэрээний нийт төсөвт өртөг,

3) Тогтоосон хугацаа байхгүй эсхүл төсөвт өртгийг тооцох үед хугацааг нь тогтоох боломжгүй нийтийн гэрээний тухайд төсөвт өртгийг сарын төлбөрийг 48 дахин үржүүлэн тооцох.



(2) Шинж чанарын хувьд ердийн эсхүл тодорхой хугацаанд гэрээг шинэчлэн байгуулах нийтийн нийлүүлэлтийн буюу нийтийн үйлчилгээний гэрээний төсөвт өртөг нь:

1) Хэрэв боломжтой бол худалдан авсан эсхүл захиалсан тоо ширхэгт гарсан өөрчлөлтийг тооцох эсхүл дараагийн хугацааны үнэд оруулан тооцох замаар өмнөх 12 сар эсхүл өмнөх санхүүгийн буюу төсвийн жилийн хугацаанд байгуулсан ижил төстэй дараалан байгуулсан гэрээнүүдийн нийт өртөг,

2) Эхний нийтийн гэрээ байгуулагдсанаас хойш 12 сарын хугацаанд эсхүл санхүүгийн буюу төсвийн жилийн хугацаанд байгуулагдсан ижил төстэй дараалан байгуулсан гэрээнүүдийн нийт төсөвт өртөг.

(3) Даатгалын үйлчилгээний нийтийн гэрээний төсөвт өртгийг даатгалын шимтгэл, бусад хэлбэрийн урамшуулалд үндэслэн тооцно.

(4) Банкны буюу бусад төрлийн санхүүгийн үйлчилгээний төсөвт өртгийг үйлчилгээний хураамж, шимтгэл, хүү, бусад төрлийн урамшуулалд үндэслэн тооцно.

(5) Төлөвлөлтийн үйлчилгээний нийтийн гэрээний төсөвт өртгийг үйлчилгээний хураамж, шимтгэл, бусад төрлийн урамшуулалд үндэслэн тооцно.

(6) Нийтийн гэрээний нийт өртгийг заагаагүй үйлчилгээний гэрээний төсөвт өртгийг тооцох үндэслэл нь:

1) 48 сар буюу түүнээс бага хугацаатай, тогтоосон хугацаатай нийтийн гэрээний тухайд нийтийн гэрээний хүчинтэй хугацаанд нийт төсөвт өртгийг тооцох

2) Тогтоосон хугацаагүй эсхүл 48 сараас дээш хугацаатай нийтийн гэрээний тухайд, 1 сард үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг 48 дахин үржүүлэн тооцох.

## **§ 22. Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээний төсөвт өртгийг тооцох**

(1) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээний төсөвт өртгийг нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай, тендерт оролцогчид шилжүүлсэн объектуудыг шилжүүлэх үеийн төсөвт өртгийг нэмж тооцсон, нэг эсхүл үйл ажиллагааны хувьд уялдаа холбоотой өөр бусад барилгад явуулах нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төсөвт өртөгт үндэслэн тогтооно.

(2) Объектыг нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил явагдах хугацаанд тендерт оролцогчийн хэрэгцээнд өгч, тухайн объект нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх явцад бүрэн элэгдэлд ороогүй бол тендерт оролцогчийн ашиглах

хугацаан дахь тухайн объектыг ашиглах зах зээлийн дундаж үнийг нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төсөвт өртөгт нэмж тооцно.

### **§ 23. Нийтийн худалдан авалтыг багцад хуваах**

(1) Нийтийн худалдан авалт явуулах журмыг хэрэглэхээс зайлсхийх эсхүл энэ хуульд заасан шаардлагыг биелүүлэхээс татгалзах зорилгоор, ялангуяа гэрээний объект нь нэг төрлийн буюу хоорондоо уялдаа холбоотой, үйлчилгээ буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил нь нэг зорилгод чиглэсэн бол захилагч байгууллага нь нийтийн худалдан авалтыг хэд хэдэн багцад хуваах эрхгүй.

(2) Багцад хуваасан нийтийн худалдан авалтын гэрээ тус бүрт эрх олгохдоо, бүх багцын нийлбэр өртгөөр тодорхойлогдсон нийтийн гэрээний эрх олгоход хэрэглэсэн журмыг баримтална.

(3) Захиалагч байгууллага нийтийн худалдан авалтын бүх багцын нийлбэр өртөг нь олон улсын босго үнэд хүрсэн буюу түүнээс давсан бол энэ хэсгийн 2-р дэд хэсэгт заасан шаардлагаас чөлөөлөгдөж болох бөгөөд багцуудын нийлбэр өртөг нь нийтийн худалдан авалтын 20 хувиас хэтрээгүй, багц тус бүрийн НӨАТ тооцоогүй өртөг нь дараахи хэмжээнээс бага бол холбогдох нийтийн гэрээ байгуулах багцын төсөвт өртөг бүхий нийтийн гэрээ байгуулах журмыг баримтална. Үүнд:

- 1) Нийтийн нийлүүлэлтийн буюу нийтийн үйлчилгээний гэрээний тухайд 80 мянган евро
- 2) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил гүйцэтгүүлэх гэрээний тухайд 1 сая евро.

### **§ 24. Нэг худалдан авалтын журмын хүрээнд нийтийн худалдан авалтыг багцад хуваах**

Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авах төсөвт өртөгт бүх багцын нийлбэр өртгийг тооцох, худалдан авах мэдэгдэлд тендерт оролцогч нэг буюу хэд хэдэн эсхүл бүх багцад саналаа ирүүлж болохыг тодорхой заах замаар нэг худалдан авалтын журмын хүрээнд нийтийн худалдан авалтыг хэд хэдэн багцад хувааж болно.

## **2-Р БҮЛЭГ**

### **Бүлэг 2**

#### **ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ**

##### **Дэд бүлэг 1**

**Худалдан авах журмын төрлүүд, тэдгээрийг хэрэглэх**

## **§ 25. Нээлттэй, хязгаарлагдмал худалдан авах журам**

(1) Нээлттэй журам гэдэг нь 12.3 хэсэгт заасан шаардлагууд болон уг хэсгийн үндсэн дээр тогтоосон боломжит хязгаарлалтад нийцсэн аливаа сонирхогч этгээд (цаашид энэ хэсэгт *сонирхогч этгээд* гэх) тендерийн санал өгөх бололцоог хангасан худалдан авах журам юм.

(2) Хязгаарлагдмал журам гэдэг нь аливаа сонирхогч этгээд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж болох боловч захиалагч байгууллага нь өөрийн зорилгод нийцүүлэн, үл ялгаварлах шалгуураар сонгож, тендерийн урилга олгосон өрсөлдөгч тендерийн санал өгөх боломжтой худалдан авах журам юм.

(3) Захиалагч байгууллага нь энэ хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг нээлттэй эсхүл хязгаарлагдмал журмаар зохион байгуулах үүрэгтэй.

## **§ 26. Өрсөлдөөнт хэлцэл**

(1) Өрсөлдөөнт хэлцэл гэдэг нь аливаа сонирхогч этгээд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж, захиалагч байгууллага нь гүйцэтгэл, үйл ажиллагааны шалгууруудын талаарх хэрэгцээ шаардлагад нь нийцсэн нэг буюу түүнээс дээш боломжит шийдлийг бий болгох зорилгоор өөрийн зорилгод нийцүүлэн, үл ялгаварлах шалгуураар шалгаруулсан нэр дэвшигчидтэй хэлцэл хийх худалдан авах журам юм. Захиалагч байгууллага нь хэлцлийн дүнд сонгосон нэр дэвшигчддээ урилга өгч, гэрээний мэдэгдэл эсхүл хэлцэл хийх урилгад заасан тендерийн үнэлгээний шалгууруудад үндэслэн амжилттай тендерийн саналыг сонгоно.

(2) 33-р хэсгийн заалтуудын дагуу хэрэгцээ шаардлагад нийцсэн техникийн шийдлийг бодитой тодорхойлох боломжгүй эсхүл худалдан авалттай холбоотой хуулийн буюу санхүүгийн нөхцөл байдлыг хангалттай нарийвчилсан байдлаар заах боломжгүй байх тохиолдолд, тэрчлэн нээлттэй эсхүл хязгаарлагдмал журмын дүнд нийтийн гэрээг үндэслэлгүй зардалтай буюу техникийн асуудалтайгаар байгуулахаас зайлсхийх боломжтой байх тохиолдолд болон захиалагч байгууллага нийтийн гэрээ байгуулах эрхийг эдийн засгийн хувьд хамгийн ашигтай тендерийн саналд өгсөн зэрэг тохиолдолд захиалагч байгууллага нь худалдан авах ажиллагааг өрсөлдөөнт хэлцлийн журмаар явуулах эрхтэй.

(3) Нийтийн худалдан авалтын тооцоолсон өртөг нь олон улсын босго үнээс бага байх нөхцөлд захиалагч байгууллага нь энэ хэсгийн 2-р зүйлд заасан нөхцлийг үл харгалзан, худалдан авах ажиллагааг өрсөлдөөнт хэлцлийн хэлбэрээр зохион байгуулах эрхтэй.

## **§ 27. Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэж тохиролцох журам**

(1) Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлж тохиролцох журам нь аливаа сонирхогч этгээд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргаж, захиалагч байгууллага нь өөрийн зорилгод нийцүүлэн, үл ялгаварлах шалгуураар сонгосон дор хаяж гурван өрсөлдөгчдөд тендерт оролцох урилга явуулж, тэдгээрийн гаргасан тендерийн саналыг гэрээний бичиг баримтад заасан шаардлагад нийцүүлэх байдлаар тохиролцож, амжилттай тендерийг сонгох худалдан авах журам юм.

(2) Захиалагч байгууллага нь дараах тохиолдолд гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэж тохиролцох журмыг хэрэглэх эрхтэй. Үүнд:

1) нийтийн худалдан авалтын эхний нөхцөл үндсэндээ өөрчлөгдөөгүй үед нээлттэй, хязгаарлагдмал журам эсхүл өрсөлдөөнт хэлцлийн дүнд гэрээний баримт бичиг эсхүл гэрээний мэдэгдэлд дурдсан шаардлагад нийцсэн нийцэх тендерт оролцогч байхгүй тохиолдолд,

2) нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил, бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний шинж чанар эсхүл тэдгээрийг дагалдах эрсдэл нь нийтийн гэрээний төсөвт өртгийг тогтоох боломжгүй болгосон тохиолдолд

3) Нийтийн гэрээний объект болж буй үйлчилгээ, түүний дотор энэ хуулийн 2-р хавсралтын 6-р ангилалд хамаарах үйлчилгээ, оюуны өмчийн эрхтэй холбоотой үйлчилгээ, тухайлбал, зураг төслийн ажилтай холбоотой үйлчилгээ нь нийтийн гэрээ байгуулахад нийтийн гэрээний нөхцлийг нээлттэй буюу хязгаарлагдмал журмаар хангалттай нарийвчлалтайгаар тодорхойлох боломжгүй байх тохиолдолд,

4) Нийтийн гэрээний объект болж буй ажлын гэрээ нь зөвхөн судалгаа, боловсруулалт эсхүл туршилтын зорилготой, ашиг олох эсхүл судалгаа боловсруулалтын зардлаа нөхөхөд чиглээгүй тохиолдолд;

(3) Нийтийн худалдан авалтын төсөвт өртөг нь олон улсын босго үнээс бага байх нөхцөлд захиалагч байгууллага нь энэ хэсгийн 2-р зүйлд заасан нөхцлийг үл харгалзан, гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэж тохиролцох журмаар худалдан авах ажиллагааг явуулах эрхтэй.

## **§ 28. Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журам**

(1) Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмыг хэрэглэхдээ захиалагч байгууллага нь өөрийн сонгосон нэг буюу түүнээс дээш сонирхогч этгээдэд

гэрээний баримт бичгийг урьдчилан өгсний дараа нийтийн гэрээний нөхцлийн талаар тохиролцоно.

(2) Захиалагч байгууллага нь гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмыг худалдан авах журам болгон дараахи тохиолдолд хэрэглэх эрхтэй. Үүнд:

1) Нээлттэй эсхүл хязгаарлагдмал журмын явцад ямар нэг тендерийн санал эсхүл худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирээгүй эсхүл бүх ирүүлсэн тендерийн санал нийтийн худалдан авалтын эхний нөхцөл үндсэндээ өөрчлөгдөөгүй байхад гэрээний баримт бичигт заасан нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтоос шинж чанарын хувьд өөр байх,

2) техникийн буюу уран сайхны шалтгаан эсхүл тусгайлсан эрхийг хамгаалахтай холбоотой шалтгаанаар нийтийн гэрээг зөвхөн тодорхой нэг тендерт оролцогчтой байгуулж болно;

3) Захиалагч байгууллагад түүнээс шалтгаалахгүйгээр учирсан гэнэтийн нөхцөл байдлын улмаас үүссэн онцгой шаардлага гарч, энэ хуулийн 35-д заасан хугацааг баримтлах боломжгүй тохиолдолд нийтийн гэрээг шууд байгуулж болно.

(3) Европын Комиссын хүсэлтээр захиалагч байгууллага нь энэ хэсгийн 2-р дэд хэсгийн 1-д заасан үндэслэлийг хэрэгжүүлж буй талаараа холбогдох тайланг Сангийн яамаар дамжуулан тус комисст илгээнэ.

(5) Энэ хэсгийн 2-р дэд хэсэгт заасан үндэслэлд нэмэлт болгон нийлүүлэлтийн гэрээ байгуулах тохиолдолд захиалагч байгууллага нь гэрээний мэдэгдлийг нийтлэлгүйгээр тохиролцох журмыг дараах тохиолдолд хэрэглэх эрхтэй. Үүнд:

1) гэрээний объектийг цэвэр судалгаа, туршилт, шинжилгээ эсхүл боловсруулалтын зорилгоор үйлдвэрлэсэн, судалгаа боловсруулалтын үйл ажиллагаатай холбоотой зардлыг нөхөх зорилгоор олон тоогоор үйлдвэрлээгүй тохиолдолд,

2) нийтийн нэмэлт гэрээний хугацаа гурван жилээс хэтрэх ёсгүй бол анхны тендерт оролцогчоос худалдан авсан бараа бүтээгдэхүүнээ хэсэгчлэн солих эсхүл түүнийг бүрэн гүйцэд болгох зорилгоор анхны тендерт оролцогчоос худалдан авах тохиолдолд, тэрчлэн нийлүүлэгчээ солих нь явагдаж буй үйл ажиллагаатай нийцэхгүй буюу техникийн хүндрэл үүсгэж болзошгүй нөхцөлд,

3) түүхий эдийн зах зээлээс худалдан авсан тохиолдолд,

4) татан буулгах ажиллагаа явагдаж эхэлсэн этгээд эсхүл зээлдэгчидтэй байгуулсан гэрээний үндсэн дээр дампууралд орсон этгээдээс нэн ашигтай нөхцлөөр худалдан авалт хийх тохиолдолд.

(5) Ажил ба үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгохдоо энэхүү хэсгийн 2-р дэд хэсэгт дурдсан үндэслэлүүдээс гадна захиалагч байгууллагууд дараахи тохиолдолд гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмыг ашиглаж болно. Үүнд:

1) анхны төсөл буюу анх байгуулсан нийтийн гэрээнд тусгагдаагүй байсан нэмэлт ажил буюу үйлчилгээг тухайн тендерт оролцогчоор гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч урьдчилан таамаглашгүй нөхцөл байдлын улмаас анх байгуулсан нийтийн гэрээнд заасан ажил буюу үйлчилгээг гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай болсон, ингэхдээ анх байгуулсан нийтийн гэрээний өртгийн 20 хүртэлх хувьтай тэнцэхээр байгаа бол тэдгээр нэмэлт ажил үйлчилгээ нь техникийн болон эдийн засгийн хувьд захиалагч байгууллагад ихээхэн зардал гаргахгүйгээр анх байгуулсан гэрээнээс салгаж авч үзэх аргагүй бол, эсхүл тэдгээр нэмэлт ажил үйлчилгээ нь анх байгуулсан нийтийн гэрээг хэрэгжүүлж дуусгахад зайлшгүй шаардлагатай учраас тухайн тендерт оролцогчид гэрээ байгуудлах эрх олгосон,

2) анхны нийтийн гэрээг байгуулах эрхийг тендерт оролцогчид өгсөн захиалагч байгууллага уг тендерт оролцогчид түүнтэй ижил төстэй ажил буюу үйлчилгээг давтсан шинжтэй шинэ ажил буюу үйлчилгээг явуулах эрхийг олгож болно. Гэхдээ уг ажил буюу үйлчилгээ нь нээлттэй буюу хаалттай журмын үндсэн дээр 3 жилийн өмнө анхлан байгуулсан нийтийн гэрээний анхны төсөлтэй нийцэх ёстой бөгөөд гэрээний мэдэгдэлд тийм нийтийн гэрээ байгуулж болох талаар дурдсан байна.

(6) Захиалагч байгууллага энэхүү хэсгийн 2-р хэсэгт дурдсан үндэслэлүүдээс гадна зураг төслийн уралдааны ялагч буюу ялагчдын аль нэгтэй үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгохдоо хэрэв энэ тухай зураг төслийн уралдааны мэдэгдэлд заасан тохиолдолд худалдан авах ажиллагааг гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмаар зохион байгуулах эрхтэй.

Зураг төслийн уралдааны ялагчдын аль нэгтэй нийтийн гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд бүх ялагчидтай хэлэлцээ хийнэ.

(7) Захиалагч байгууллага 2 ба 4-6-р дэд хэсэгт дурдсан үндэслэлүүдээс гадна хэрэв нийтийн гэрээний төсөвт өртөг олон улсын босго үнээс доогуур байгаа тохиолдолд болон

доор дурдсан үндэслэлээр гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмаар зохион байгуулах эрхтэй. Үүнд:

- 1) Нийтийн гэрээний объект нь номын сангийн баримт бичиг буюу өгөгдлийн санг ашиглах зөвшөөрөл бол,
- 2) Маш богино хугацаанд онцгой хөнгөлөлттэй нөхцлөөр зах зээлийн ердийн үнээс мэдэгдэхүйц доогуур үнээр авсан бараа бүтээгдэхүүн,
- 3) гадаад улсад байгаа дипломат төлөөлөгчийн газарт зориулан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ худалдан авах, ажил гүйцэтгэх гэрээ
- 4) энэхүү хуулийн 10-р зүйлийн 1-р дэд хэсгийн 1, 2-т заасны дагуу хорих байгууллагаас буюу хорих байгууллагын үйлдвэрлэлийн нэгжийг удирддаг төрийн компаниас захиалагч байгууллагын худалдан авсан бараа буюу үйлчилгээ;
- 5) нийтийн гэрээний объект нь агаарын тээврийн үйлчилгээ бол.

## **Хэсэг 2**

### **Худалдан авах ажиллагааны ерөнхий зарчмууд**

#### **§ 29. Худалдан авах ажиллагааг нээх ба хаах**

(1) Захиалагч байгууллага нээлттэй, хязгаарлагдмал, эсхүл гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэх буюу өрсөлдөөнт санал бүхий худалдан авах ажиллагааг эхлэхдээ гэрээний мэдэгдлийг бүртгэлийн цахим хуудсаар буюу бүртгэлээр дамжуулан нийтэлнэ.

(2) Худалдан авах ажиллагаа нь урьдчилан нийтлэлгүйгээр хэлэлцэн тохирох журмаас бусад тохиолдолд гэрээний мэдэгдлийг гэрээний бүртгэлд нийтлэснээр эхлэнэ.

Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр хэлэлцэн тохирох журам нь захиалагч байгууллагын зүгээс сонгосон нэг буюу хэд хэдэн сонирхогч талд гэрээний баримт бичгийг хүлээлгэн өгснөөр хэрэгжиж эхлэнэ.

(3) Худалдан авах ажиллагаа нь дараахи тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

- 1) нийтийн гэрээ эсхүл Ерөнхий гэрээ байгуулах эрх олгосноор
- 2) Шаардлага хангасан тендерийн санал ирээгүйгээс бүх тендерийн саналыг хүлээж авахаас татгалзсан,
- 3) энэхүү хуулийн 49-р зүйлийн заалтад үндэслэн бүх тендерийн саналыг хүлээж авахаас татгалзсан,
- 4) худалдан авах ажиллагаанаас бүх тендерт оролцогчид буюу өрсөлдөгчдийг хассан эсхүл шалгаруулалгүй орхисон,

5) энэхүү хуульд заасан журмын дагуу тогтоосон хугацааны дотор худалдан авах ажиллагаанд оролцох тендерийн санал эсхүлд хүсэлт ирээгүй,

6) Нийтийн худалдан авалтын газар эсхүл захиалагч байгууллага нь худалдан авах ажиллагааг тус Газрын тодорхойлолт эсхүл түүний санаачлагаар үндэслэл бүхий шаардлага байгаа гэж үзсэн тохиолдолд хүчингүй гэж зарлаж болно.

7) нэг ч тендерт оролцогч тендерийн саналын хугацааг сунгахыг зөвшөөрөөгүй тохиолдолд бүх тендерийн саналын хугацааг хүчингүй болгох,

(4) Хэрэв захиалагч байгууллага нийтийн худалдан авалтыг нэг худалдан авалтын хүрээнд багцад хуваасан бол аливаа багцийн хувьд 3-р дэд хэсэгт заасан аливаа үндэслэл байгаа тохиолдолд буюу 3-р дэд хэсгийн 6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг хүчингүй гэж зарласан шийдвэр гарсан тохиолдолд худалдан авах ажиллагаа дуусгавар болно.

### **§ 30. Мэдээллийг урьдчилан мэдэгдэх**

Захиалагч байгууллага энэхүү хуулийн 35-р зүйлийн 5 дахь дэд хэсэгт заасны дагуу тендерийн санал ирүүлэх хугацааг богиносгох хүсэлтэй байгаа бол захиалагч байгууллага бүртгэлд энэ тухай мэдээллийг урьдчилан мэдэгдэх ёстой. Үүнд:

1) санхүүгийн буюу төсвийн жилийн хугацаанд авахаар төлөвлөж буй энэхүү хуулийн 2-р хавсралтын А хэсэгт дурдсан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний төрөлд нийцүүлэн энэхүү хуулийн 2-р хавсралтын А хэсэгт дурдсан бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ авах нийтийн гэрээний санхүүгийн буюу төсвийн жил эхэлсэн даруйд;

2) төлөвлөсөн ажлын гэрээний тухайд холбогдох шийдвэр батлагдсан даруйд.

### **§ 31. Гэрээний баримт бичиг**

(1) Захиалагч байгууллага нь нээлттэй журмын хувьд худалдан авах ажиллагааг эхлэхээс өмнө, хязгаарлагдмал журмын хувьд гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэлгүйгээр тохиролцох журмаар болон гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэж тохиролцох журмаар худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан өдрөөс хойшлуулалгүйгээр гэрээний баримт бичгийг бэлтгэнэ.

Гэрээний баримт бичгийг энэхүү хуульд буюу түүнд үндэслэсэн гаргасан хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн бичгээр буюу захиалагч байгууллага цахим хэлбэр ашиглах тухай гэрээний мэдэгдэлд заасан тохиолдолд цахим хэлбэрээр бэлтгэнэ.



(2) Гэрээний баримт бичиг нь энэ хуульд өөрөөр заагаагүй, эсхүл гэрээний мэдэгдэлд холбогдох мэдээллийг дурдаагүйгээс бусад тохиолдолд наад зах нь доорхи мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- 1) захиалагч байгууллага гэрээний баримт бичгийг нээлттэй журмын дагуу бэлтгэсэн бол гэрээний мэдэгдэл буюу гэрээний баримт бичигт дурдсан нөхцөлд нийцүүлэн тендерийн санал өгөх санал,
- 2) энэхүү хуулийн 33-р зүйлд заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолт,
- 3) энэхүү 4-р дэд хэсэгт дурдсан нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд цаашид байгуулах нийтийн гэрээний бүх нөхцөл эсхүл нийтийн гэрээний төсөл,
- 4) захиалагч байгууллагын зүгээс өрсөлдөөнт тендерийн саналд шаардаж буй эдгээр бүх нөхцөл байдал,
- 5) тендерийн саналын бүтэц ба тендерийн саналыг хаяглахад шаардлагатай шаардлагатай баримт бичгийн жагсаалт,
- б) хэл ба тендерийн саналыг бэлтгэх хэлнүүд,
- 7) тендерийн саналыг ирүүлэх бүтэц ба мөнгөн тэмдэгт,
- 8) тендерт оролцогчид тендерийн санал дахь гэрээний мэдэгдэл ба гэрээний баримт бичигт дурдсан бүх нөхцөлийг хангаж байгаагаа нотлох шаардлага болон захиалагч байгууллага өрсөлдөөнт тендерийн санал шаардаж байгаа нөхцөлд тендерийн санал ирүүлэх;
- 9) туслан гүйцэтгэгчтэй байгуулахаар төлөвлөж байгаа нийтийн гэрээний хэмжээ, нийтийн гэрээг хэрэгжүүлэхэд шууд оролцох туслан гүйцэтгэгчдийн нэрс болон туслан гүйцэтгэгчдэд өгөхөөр төлөвлөж байгаа нийтийн гэрээний хэсгийн онцлог ба хэмжээний талаархи мэдээлэл, тэрчлэн тендерийн саналд тендерт оролцогч нь зөвхөн захиалагч байгууллагын зөвшөөрлөөр, тэдгээрийг худалдан авах ажиллагаанаас хасах үндэслэл байхгүйг нотолсон нотолгоо авсны дагуу нийтийн гэрээний үндсэн хэсгийг хэрэгжүүлэхэд туслан гүйцэтгэгчийг татан оролцуулж болзошгүй тухай нотолгоо зэргийг тендерт оролцогч нь тендерийн саналдаа тусгах шаардлагатай;
- 10) тендерийн санал ирүүлсэн огноо ба газар,
- 11) тендерийн саналын хүчинтэй байх доод талын хугацаа,

- 12) захиалагч байгууллага тендерийн барьцаа шаардаж байгаа тохиолдолд тендерийн барьцааны хэмжээ,
- 13) гэрээний баримт бичгийн агуулгын талаар нэмэлт мэдээлэл авч болох холбоо барих хаягийн мэдээлэл,
- 14) тендерийн саналыг нээх газар ба цаг,
- 15) захиалагч байгууллага шаардлагатай гэж үзэж байгаа тохиолдолд тендерийн саналыг хүлээж авахгүй байх үндэслэлүүд.

(3) Захиалагч байгууллага нь хэрэв гэрээний мэдэгдэлд энэ талаар дурдаагүй бол гэрээний баримт бичигт нийтийн гэрээг байгуулахдаа эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байдлын үндсэн дээр эсхүл хамгийн доод үнийн саналыг харгалзаж үзэхийн алин болохыг дурдана.

Захиалагч байгууллага нь түүний хувьд эдийн засгийн хамгийн үр ашигтай байдал нь зөвхөн тендерийн үнийн саналаас шалтгаалах бөгөөд цаашид байгуулах нийтийн гэрээнүүдийн бусад бүх нөхцөл, түүний дотор нийтийн гэрээний объекттой холбоотой шаардлагуудыг гэрээний баримт бичигт бүрэн дүүрэн тусгасан тохиолдолд нийтийн гэрээ байгуулах эрхийг зөвхөн хамгийн доод үнэ бүхий тендерийн саналд үндэслэн байгуулж болно.

4) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээг эдийн засгийн хамгийн үр ашигтай байдалд үндэслэн байгуулах тохиолдолд нийтийн гэрээний объекттой холбоотой юун түрүүнд чанар, үнэ, техникийн үнэлгээ, гоо зүйн ба үйл ажиллагааны шинж чанар, хүрээлэн буй орчинд нөлөөлөх шинж чанар, үйл ажиллагааны зардал, техник эдийн засгийн үндэслэл, борлуулсны дараахи үйлчилгээ болон техникийн туслалцаа, тэдгээрийн үнэ, тэрчлэн тухайн ажил ба үйлчилгээний чанар тэдгээрээс шууд шалтгаалах бол үйлчилгээ буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг шууд хариуцах этгээдийн тусгайлсан чадвар буюу туршлага, нийтийн гэрээг гүйцэтгэх хугацаа зэрэг тендерийн саналыг үнэлэх шалгуурыг захиалагч байгууллага тодорхойлно.

Захиалагч байгууллага эдийн засгийн хамгийн үр ашигтай тендерийн саналын бодит үндэслэлтэй хэмжээг тогтоох бөгөөд түүнийг сонгогдсон тендерийн санал бүрийг үнэлэх шалгуурт тусгана.

(5) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээг эдийн засгийн хамгийн үр ашигтай байдалд үндэслэн байгуулах тохиолдолд, мөн захиалагч байгууллага гэрээний мэдэгдэл ба

гэрээний бичиг баримтад нийцсэн шийдлээс гадна тендерийн саналд хувилбарт шийдэл санал болгох боломжтойг дурдсан бол тэдгээр хувилбарт шийдлүүдэд тавигдах шаардлага хийгээд хувилбарт шийдлүүдийн нөхцлийг гэрээний баримт бичигт тодорхойлно.

(6) Захиалагч байгууллага нь өрсөлдөөнт хэлцэл эсхүл гэрээний мэдэгдлийг үе шаттайгаар урьдчилан нийтэлж тохиролцох журмаар зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд үе шат бүрт хэлцлийн объект болох шийдлүүдийн тоог цөөлөх буюу хэлэлцэж буй тендерийн саналын тоог цөөлөхөөр төлөвлөж байгаа бол энэ тухайгаа гэрээний баримт бичиг, хэлцэл эхлүүлэх урилга болон гэрээний мэдэгдэлд зааж өгнө.

(7) Захиалагч байгууллага нь үйлчилгээний эсхүл ажлын гэрээ байгуулахдаа тендерт оролцогч үйлчилгээний дийлэнхи хувь буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын дийлэнхи хувийг биечлэн гүйцэтгэх (нийтийн гэрээний дийлэнхи хэсгийг гүйцэтгэх) нөхцөл тавьж болно. Нийтийн гэрээний шинж чанарт үндэслэсэн тийм хязгаарлалт нь нийтийн гэрээг чанартай гүйцэтгэх болон нийтийн гэрээний гүйцэтгэлийг магадлан шалгахад шаардлагатай байх ёстой бөгөөд эсхүл бусад бодитой шалтгаанаар болон тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагад нийцсэн байх ёстой.

Тендерт оролцогчтой холбоотой компанийн хувьд давхар гэрээ байгуулах талаар тавьсан хязгаарлалт хамаарахгүй.

(8) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд цахим дуудлага худалдаа явуулах талаар дурдсан тохиолдолд гэрээний баримт бичигт наад зах нь доорхи нэмэлт мэдээллийг багтаасан байх ёстой. Үүнд:

- 1) Тендерийн саналын тоон буюу хувьчилсан үзүүлэлтүүд, цахим дуудлага худалдааны объектын үнэ өртгийн харьцуулалт,
- 2) нийтийн гэрээний объектоос шалтгаалан энэхүү дэд хэсгийн 1-т заасан үзүүлэлтүүдийн үнэ өртөгт тавигдах хязгаарлалт,
- 3) цахим дуудлага худалдааны явцад тендерт оролцогчдод өгөх мэдээлэл, шаардлагатай бол тэдгээр мэдээллийг өгөх огноо,
- 4) цахим дуудлага худалдааг явуулах журмын тухай мэдээлэл
- 5) цахим дуудлага худалдаанд оролцогчдод тавигдах нөхцлүүд, ялангуяа дуудлага худалдааны явцад өмнөхөөсөө ялгарах шинэ үнэлгээ буюу үнийн хамгийн бага зөрүү,
- 6) интернет холболтод ашиглагдах электрон төхөөрөмж, зохицуулалт болон техникийн тодорхойлолтын талаар холбогдох мэдээлэл

(9) Хэрэв захиалагч байгууллагууд энэхүү хуулийн 13-р зүйлд заасны дагуу худалдан авах ажиллагааг хамтран зохион байгуулах бол нийтийн худалдан авах ажиллагааг явуулах эрх бүхий захиалагч байгууллага нь гэрээний баримт бичигт нийтийн гэрээнд оролцож болох захиалагч байгууллагуудыг тодорхойлж, тэдгээрийн нийтийн гэрээн дэх ажил үүргийн хуваарь, нийтийн гэрээнээс үүсэх үүрэг хариуцлагыг биелүүлэхэд оролцох хуваарийг тодорхойлно.

(10) Захиалагч байгууллага нь гэрээний баримт бичгийг сонирхсон этгээдэд үнэ төлбөргүй танилцах боломжоор хангана. Захиалагч байгууллага нь гэрээний баримт бичигтэй биечлэн буюу цахим хуудсаар танилцах боломжоор хангана. Захиалагч байгууллага нь гэрээний баримт бичгийг цаасан хэлбэрээр хүргэхэд шаардагдах хураамж авч болох бөгөөд тэрхүү хураамж нь гэрээний баримт бичгийг хувилах болон хүргэх зардлаас хэтрэх ёсгүй.

### **§ 32. Техникийн тодорхойлолт**

(1) Энэхүү хуульд зааснаар “техникийн тодорхойлолт” гэдэг нь захиалагч байгууллага холбогдох салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдэд зориулан нийтийн гэрээний объектыг тодорхойлохдоо хэрэглэж буй ойлгомжтой бөгөөд оновчтой нэр томъёог хэлнэ. Үүнд:

- 1) ажлын гэрээний объект болох нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын шинж чанар болоод техникийн шаардлагуудын цогц,
- 2) нийлүүлэлтийн буюу үйлчилгээний гэрээний объект болох бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний шинж чанар ба үндсэн онцлогийн жагсаалт,

(2) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажилд тавигдах техникийн шаардлагуудын цогц нь захиалагч байгууллагын тогтоосон объектын зорилго ба ашиглалтад нийцэж байгаа эсэхийг үнэлж болохуйц хэлбэрээр материал буюу бараа бүтээгдэхүүнд тавигдах шаардлагуудыг тодорхойлно. Эдгээр шаардлага нь хүрээлэн буй орчны шаардлага ба барилгын ажлын шаардлага, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарцыг хангах шаардлага, тохирч буй эсэх үнэлгээ, гүйцэтгэлийн шаардлага, аюулгүй байдал эсхүл хэмжилтүүд, чанарын баталгааны арга хэрэгсэл, ашигласан нэр томъёо, бэлгэ тэмдэг, тест ба тестийн арга барил, сав баглаа боодлын шаардлага, хаяг шошго болон үйлдвэрлэлийн процесс ба технологи зэргийг багтааж болно. Түүнчлэн дурдсан шаардлага нь захиалагч байгууллагын тодорхойлж болох бөгөөд баригдсан барилгууд ба

тэдгээрийн материал, бүрдэл хэсэгтэй холбоотой барилгыг төлөвлөх ба түүний үнэ өртөгтэй холбоотой тодорхойлолт, тест, хяналт тавих ба хүлээн авах нөхцлүүд, ашиглалтын заавар ба барилгын аргад тавигдах шаардлага, технологи ба бусад бүх техникийн нөхцлүүдийг багтааж болно.

(3) Бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний үндсэн шинж чанарын тухай жагсаалт нь хүрээлэн буй орчны шаардлага, чанар ба барилгад тавигдах шаардлага, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарцыг хангах шаардлага, тохирлын үнэлгээ, үр дүнтэй байдал, бүтээгдэхүүний гүйцэтгэлд тавигдах шаардлага, аюулгүй байдал буюу хэмжилтүүд, тодорхой нэрээр түгээгдэх бүтээгдэхүүний хувьд дагаж мөрдөх шаардлага, ашигласан нэр томъёо, бэлгэ тэмдэг, тест ба тестийн арга барил, сав баглаа боодол, хаяг шошго тавих, хэрэглэгчийн заавар болон үйлдвэрлэлийн процесс ба технологи, тохирлын үнэлгээний ара барил зэргийг багтааж болно.

### **§ 33. Техникийн тодорхойлолтыг боловсруулах**

(1) Тухайн салбарт техникийн стандарт байхгүй бол нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтыг дараахи зүйлст үндэслэн боловсруулна. Үүнд:

- 1) Европын стандартад шилжих Эстонийн стандарт;
- 2) Европын стандарт;
- 3) Европын Холбооны гишүүн улсаас томилогдсон эрх бүхий байгууллагаас баталсан бөгөөд техникийн үүднээс үзэхэд тухайн бүтээгдэхүүнийн шинж чанар нь нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын шинж чанар болоод ашиглалтын нөхцлүүдэд тавигдах үндсэн шаардлагуудыг хангасан тухай Европын техникийн зөвшөөрөл;
- 4) Европын Холбооны гишүүн улсаас баталсан бөгөөд Албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэн журмын дагуу боловсруулсан нэгдсэн техникийн тодорхойлолт;
- 5) Олон улсын стандарт;
- 6) Европын Холбооны аль нэг стандартын байгууллагаас гаргасан техникийн хяналтын систем;
- 7) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл, нягтлан бодох бүртгэлийн арга барил эсхүл гүйцэтгэл, эсхүл бараа бүтээгдэхүүн ашиглахтай холбоотой Эстонийн стандарт, Эстонийн техникийн зөвшөөрөл эсхүл Эстонийн техникийн тодорхойлолт.

(2) Захиалагч байгууллагын зүгээс техникийн тодорхойлолтын талаар энэхүү хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан үндэслэлийг дурдах бүртээ “эсхүл тэнцүү” гэсэн тэмдэглэлийг ашиглана.

(3) Энэхүү хэсгийн 1-р дэд хэсэгт хүрээлэн буй орчны шаардлагыг оролцуулан дурдсан үндэслэлийн оронд техникийн тодорхойлолтыг бүхэлд нь буюу нийтийн гэрээний объектод тавигдах гүйцэтгэлийн тодорхойлолт эсхүл үүрэг функцийн шаардлагад үндэслэсэн зарим онцлог шинжийг харгалзан боловсруулж болно. Тэрхүү тодорхойлолт нь тендерт ороцогчийн зүгээс нийтийн гэрээний объектыг болон нийтийн гэрээ байгуулах эрх олгох тухай хангалттай нарийвчлан тодорхойлсон байх ёстой.

(4) Энэхүү хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан үндэслэлээр техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа захиалагч байгууллага нь 1-р хэсэгт дурдсан үндэслэлийг 3-р дэд хэсэгт дурдсан гүйцэтгэлийн буюу үүрэг функцийн шаардлагыг хангах хэрэгсэл болгон дурдаж болно.

(5) Техникийн тодорхойлолтын үндэслэлд энэхүү хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан хүрээлэн буй орчны шаардлага багтсан тохиолдолд, тэдгээр шаардлагыг Европын, Эстонийн буюу олон улсын эсхүл бусад эко-шошгыг хүлээж авах нөхцөл болсон шаардлагуудын цогц эсхүл дараахи шаардлагын үндсэн дээр тодорхойлж болно. Үүнд:

1) тэдгээр шаардлага нь нийтийн гэрээний объект болсон бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний шинж чанарыг тодорхойлоход тохиромжтой;

2) тэдгээр шаардлага нь шинжлэх ухааны мэдээлэлд үндэслэсэн бол;

3) тэдгээр эко-шошгыг батлахдаа бүх сонирхогч этгээд болон байгууллагуудад нээлттэй журмыг ашигласан;

4) тэдгээр эко-шошгыг хэрэглэх зөвшөөрлийг авах боломж бүх сонирхогч этгээдэд нээлттэй байх.

(6) Техникийн тодорхойлолтод энэхүү хэсгийн 5-р дэд хэсэгт дурдсан нөхцөлд нийцүүлэн эко-шошгыг ашиглаж байгаа бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ нь эко-шошго авахад тавигдах шаардлагын тухай техникийн тодорхойлолтыг мөрдөх шаардлагатай.

(7) Техникийн тодорхойлолт нь тодорхой тендерт оролцогчид буюу тодорхой зүйлст давуу тал олгох эсүл хасахад хүргэх тухайлсан худалдан авалтын эх сурвалж, процесс, барааны тэмдэг, патент, хэлбэр, тухайлсан гарал үүсэл буюу үйлдвэрлэлийн талаар дурдах ёсгүй. Хэрэв энэхүү хэсгийн 1,3-р дэд хэсэгт заасны дагуу нийтийн гэрээний объектын

тухай хангалттай тодорхой, ойлгомжтой тодорхойлолт өгөх боломжгүй бол нийтийн гэрээний объектоос үүдэн зайлшгүй шаардлагатай байгаа тохиолдолд тийнхүү дурдахыг зөвшөөрнө. Тийнхүү дурдахдаа “ижил тэнцүү” гэсэн үгийг хамт хэрэглэнэ.

(8) Техникийн тодорхойлолт нь тендерийн бүх оролцогчдод тендерийн санал ирүүлэхэд тэгш боломж олгох ёстой бөгөөд нийтийн худалдан авах ажиллагааг өрсөлдөөнтэйгээр явуулахад аливаа саад учруулах ёсгүй.

(9) Техникийн хувьд боломжтой бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой байх шаардлагыг нийтийн гэрээний объектоор холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа эсхүл нийтийн гэрээний объектыг бүх хүн ашиглах боломжтой байхаар техникийн тодорхойлолтыг болосруулахдаа тус тус харгалзан үзнэ.

### **§ 34. Тендерийн баталгаа**

(1) Захиалагч байгууллага нь тендерт оролцогчоос худалдан авах ажиллагааны явцад захиалагч байгуулгад тендерт оролцогчийн зүгээс үүргээ биелүүлээгүйгээс үүсэх хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн барагдуулах зорилгоор тендерийн баталгаа гаргаж өгөхийг шаардаж болно. Гэхдээ уг баталгаа нь нийтийн гэрээний төсөвлөсөн өртгийн 1 хувиас хэтэрч болохгүй.

(2) Тендерийн бүх оролцогчдоос ижил хэмжээний тендерийн баталгаа шаардана.

(3) Захиалагч байгууллага нэг худалдан авах ажиллагааны хүрээн дэх нийтийн худалдан авалтыг багц болгон хуваасан тохиолдолд зөвхөн зарим багцад тендерийн баталгаа шаардаж болно. Нэг багцад шаардагдах тендерийн баталгаа нь тендерийн бүх оролцогчдын хувьд адил байна.

(4) Захиалагч байгууллага зээлийн буюу санхүүгийн байгууллага эсхүл даатгагчийн баталгаа хэлбэрээр, эсхүл захиалагч байгууллагын тооцооны дансанд бэлнээр байршуулах хэлбэрээр тендерийн баталгаа шаардаж болно.

(5) Тендерийн баталгаа нь захиалагч байгууллагад үлдэх бөгөөд дараахи тохиолдолд түүнийг ашиглах эрхтэй:

1) Тендерт оролцогчийг худалдан авах ажиллагаанаас хассан;

2) Тендерт оролцогч тендерийн саналаа хүчинтэй байх хугацаанд нь татан авсан.

(6) Захиалагч байгууллага дараахи тохиолдолд тендерийн баталгааг тендерт оролцогчид ажлын 3 хоногийн дотор буцаан олгоно. Үүнд:

1) Нийтийн гэрээ байгуулах эрх хэрэгжиж эхлэх;

- 2) Тендерийн саналын хүчинтэй хугацаа дуусах;
- 3) Худалдан авалтыг хүчингүй гэж зарлах;
- 4) Энэхүү хуулийн 44-р зүйлийн 2-р дэд хэсэгт заасны дагуу тендерийн саналыг буцаан татах.

**§ 35. Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацаа**

- (1) Захиалагч байгууллага тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацааг нийтийн гэрээний объект, юун түрүүнд түүний онцлог, тоо хэмжээ, эзлэхүүн болон цар хэмжээг харгалзан тогтооно.
- (2) Нээлттэй журмын тухайд тендерийн санал ирүүлэх хугацаа нь бүртгэлд гэрээний мэдэгдлийг нийтлэснээс хойш 52 хоногоос багагүй байна.
- (3) Хязгаарлагдмал журам, гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтэлж тохиролцох журам болон өрсөлдөөнт хэлцлийн тухайд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацаа нь бүртгэлд гэрээний мэдэгдлийг нийтлэснээс хойш 37 хоногоос багагүй байна.
- (4) Хязгаарлагдмал журмын тухайд тендерийн санал ирүүлэх хугацаа нь тендерийн урилгыг өрсөлдөгчдөд ирүүлснээс хойш 40 хоногоос багагүй байна.
- (5) Гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтэлж тохиролцох журам болон өрсөлдөөнт хэлцлийн тухайд тендерийн санал ирүүлэх хугацааг захиалагч байгууллага ба захиалагч байгууллагаас сонгосон тендерт өрсөлдөгчдийн хоорондоо тохиролцож тогтоох бөгөөд ингэхдээ сонгогдсон бүх өрсөлдөгчдөд тендерийн санал ирүүлэх ижил хугацаа олгоно. Хэрэв тохирлоонд хүрч чадахгүй бол захиалагч байгууллага тендерийн санал ирүүлэх хугацааг тогтоох бөгөөд ингэхдээ уг хугацаа нь тендерийн урилга ирүүлснээс хойш 24 хоногоос багагүй байна.
- (6) Захиалагч байгууллага 30-р хэсэгт заасан журмын дагуу урьдчилан мэдээлэл ирүүлсэн тохиолдолд тендерийн санал ирүүлэх хугацаа нь энэхүү хэсгийн 2 ба 4-р дэд хэсэгт дурдсан худалдан авах ажиллагааны тухайд ерөнхийдөө 36 өдрөөс багагүй байна. Урьдчилан ирүүлсэн мэдээлэл нь гэрээний мэдэгдэлд байх ёстой бүх мэдээллийг багтаасан, гэрээний мэдэгдлийг ирүүлэхээс 52 өдрөөс 12 сарын өмнө бүртгэлд ирүүлсэн тохиолдолд дурдсан хугацаа нь 22 өдрөөс багагүй байна. Захиалагч байгууллага нь Бүртгэлд гэрээний мэдэгдлийг ирүүлсэн өдрөөс эхлэн гэрээний баримт бичигтэй аливаа хязгаарлалтгүй, цахим байдлаар танилцах бүрэн боломж олгосон бөгөөд гэрээний



мэдэгдэлд холбогдох цахим хуудсыг заасан тохиолдолд, дурдсан хугацааг 5 өдрөөр богиносгож болно.

(7) Нийтийн гэрээний төсөвт өртөг нийтийн худалдан авах ажиллагааны босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан боловч олон улсын босго үнээс бага байгаа тохиолдолд энэхүү хэсгийг 2-р дэд хэсэгт дурдсан хугацаа нь ажлын гэрээний тухайд дор хаяж 22 өдөр, нийлүүлэлтийн болон үйлчилгээний гэрээний тухайд дор хаяж 15 өдөр, 3-р дэд хэсэгт дурдсан хугацаа нь дор хаяж 7 өдөр, 4-р дэд хэсэгт дурдсан хугацаа нь ажлын гэрээний тухайд дор хаяж 22 өдөр бөгөөд нийлүүлэлтийн болон үйлчилгээний гэрээний тухайд дор хаяж 15 өдөр байна.

(8) Захиалагч байгууллага тендерт өрсөлдөгчид буюу худалдан авах ажиллагаанд оролцох сонирхолтой этгээдэд гэрээний баримт бичиг буюу нэмэлт мэдээллийг энэхүү хэсэгт заасан хугацаанд өгөөгүй бөгөөд тэдгээр нь хугацаандаа өргөдлөө ирүүлсэн буюу тендерийн саналыг зөвхөн гэрээний гүйцэтгэлийн газар очиж танилцсаны дараа эсхүл гэрээний баримт бичиг болон юуны түрүүнд техникийн тодорхойлолтыг боловсруулах үндэслэл болсон бүх баримт бичигт нэмэлт болгосон баримт бичгийг газар дээр нь үзэж танилцсаны дараа тендерийн санал ирүүлэх боломжтой байсан тохиолдолд захиалагч байгууллага тендерт өрсөлдөгчид буюу худалдан авах ажиллагаанд оролцох сонирхолтой бүх этгээдийг тендерийн санал ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээллээр хангах үүднээс гэрээний баримт бичиг тендерийн санал ирүүлэх эцсийн хугацаа болон тендерийн саналыг нээх хугацааг хойшлуулж болно.

(9) Захиалагч байгууллага тендерийн санал ирүүлэх буюу худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацааг шаардлагатай бол сунгаж, тендерийн саналыг нээх хугацааг өөрчилж болно. Уг хугацааг хэрэв өөрчилсөн гэрээний мэдэгдлийг бүртгэлд нийтлэхээс өмнө эсхүл гэрээний баримт бичгийн өөрчлөлтийг гэрээний баримт бичгийг хүлээн авсан бүх тендерт оролцогчид, өрсөлдөгчид болон бусад сонирхогч этгээдэд явуулахаас өмнө анхлан тогтоосон хугацаа болсон тохиолдолд сунгахгүй.

### **§ 36. Гэрээний мэдэгдэл ба гэрээний баримт бичгийг өөрчлөх**

(1) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд заасан тендерийн санал буюу худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацаа дуусахаас өмнө гэрээний мэдэгдэл ба гэрээний баримт бичгийг өөрчилж болно.

(2) Гэрээний мэдэгдлийг өөрчлөхийн тулд захиалагч байгууллага шинэ гэрээний мэдэгдлийг бүртгэлд ирүүлэх ёстой бөгөөд энэ тухайгаа гэрээний баримт бичиг хүлээн авсан бүх тендерт оролцогчид, өрсөлдөгчид болон сонирхогчдод нэн даруй мэдэгдэнэ.

(3) Гэрээний мэдэгдэл буюу гэрээний баримт бичгийг өөрчлөхдөө захиалагч байгууллага өөрчлөгдсөн гэрээний баримт бичгийг гэрээний баримт бичиг хүлээн авсан бүх тендерт оролцогчид, өрсөлдөгчид болон сонирхогчдод нэгэн зэрэг илгээнэ.

(4) ) Гэрээний мэдэгдэл буюу гэрээний баримт бичгийг өөрчлөхдөө захиалагч байгууллага нь тендерийн санал буюу худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт ирүүлэх хугацааг сунгаж болох бөгөөд ингэхдээ тендерийн санал буюу худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргах хугацаа нь энэхүү хэсгийн 3-р дэд хэсэгт дурдсан этгээдүүдийн хувьд гэрээний мэдэгдэл буюу гэрээний баримт бичгийн өөрчлөлтийг Бүртгэлийн газарт илгээснээс хойш дор хаяж энэхүү хуульд заасан холбогдох хамгийн бага хугацааны хагастай тэнцүү байна. Тэдгээр өөрчлөлт нь зөвхөн холбоо барих хаягтай холбоотой, эсхүл бусад тохиолдолд, хэрэв эх мэдэгдэл ба гэрээний баримт бичгийг үндсэн дээр бэлтгэсэн тендерийн санал нь хийгдсэн өөрчлөлтөөс үүдэн тохиромжтой байдлаа алдахгүй байх, эсхүл эх мэдэгдэлд үндэслэсэн ур чадварын шалгуурт нийцсэн бөгөөд хийгдсэн өөрчлөлтөөс болж тэрхүү шалгуур нь өөрчлөгдөхгүй тохиолдолд захиалагч байгууллага дээр дурдсан хугацааг сунгахгүй.

(5) Энэхүү хуулийн 35-р зүйлийн 9-р дэд хэсэгт заасны дагуу зөвхөн тендерийн саналыг нээх хугацааг сунгах буюу өөрчлөх тохиолдолд өөрчлөгдсөн хугацаа нь энэхүү 4-р дэд хэсгийн заалтыг дагах албагүй.

### **§ 37. Нийтийн худалдан авах ажиллагааны тайлан**

(1) Захиалагч байгууллага нийтийн худалдан авах ажиллагааны тайланг худалдан авах ажиллагаа дууссанаас хойш 10 хоногийн дотор бүртгэлийн цахим хуудсаар дамжуулан Бүртгэлд ирүүлнэ.

(2) Захиалагч байгууллага нийтийн гэрээний өртгийн НӨАТ тооцоогүй дүн нь бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээний тухайд 10 000 евро, нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын тухайд 30 000 еврогоос илүү байх тохиолдолд нийтийн худалдан авах ажиллагааны тайланг худалдан авах ажиллагаа дууссанаас хойш 10 хоногийн дотор бүртгэлийн цахим хуудсаар дамжуулан бүртгэлд ирүүлнэ. Дурдсан үүрэг нь ерөнхий гэрээнд үндэслэсэн нийтийн гэрээнд хамаарахгүй.

(3) Захиалагч байгууллага нэг худалдан авах ажиллагааны хүрээн дэх нийтийн худалдан авах ажиллагааг багц болгон хуваасан тохиолдолд зарим багцад хамаатай нийтийн гэрээг байгуулснаас хойш цаад тал нь 45 хоногийн дотор нийтийн худалдан авах ажиллагааны тайланг ирүүлэх ёстой. Гэхдээ энэ хуулийн 29-р зүйлийн 3-т заасан худалдан авах ажиллагааг дуусгах аливаа үндэслэл нь бүх багцад хамаарахгүй байх ёстой.

Захиалагч байгууллага дээрхи багцуудын аль нэгэнд 29-р зүйлийн 3-т заасан худалдан авах ажиллагааг дуусгавар болгох аливаа үндэслэл үүссэнээс хойш 45 хоногийн дотор үлдсэн багцуудад хамаарах нийтийн худалдан авах ажиллагааны тайланг тус тусад нь гаргаж өгнө.

(4) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээ эсхүл ерөнхий гэрээ дуусгавар болсноос хойш 10 хоногийн дотор нийтийн худалдан авах ажиллагааны тайлангийн хавсралтыг гаргаж өгнө. Хавсралтад дараахи зүйлс багтана. Үүнд:

1) нийтийн гэрээнд оруулсан өөрчлөлтүүд, түүний дотор өөрчлөлт оруулах болсон шалтгаан, нийтийн гэрээний заалттай харьцуулахад нийтийн гэрээний гүйцэтгэлд гарч буй томоохон ялгаа, юуны түрүүнд нийтийн гэрээний зөрчлүүд эсхүл хугацаанаас өмнө дуусгавар болгосон тухай,

2) нийтийн гэрээний шууд гүйцэтгэлд давхар гэрээний үндсэн дээр оролцсон туслан гүйцэтгэгчид, түүний дотор туслан гүйцэтгэгчдийн хийсэн гүйцэтгэл эсхүл үнэлгээний тодорхойлолт эсхүл

3) Ерөнхий гэрээнд үндэслэн хийгдсэн нийтийн гэрээний үнэлгээ эсхүл түүнд үндэслэн хийгдсэн гүйцэтгэлийн тодорхойлолт.

### **Бүлэг 3**

#### **Тендерт оролцогч ба өрсөлдөгчийн шалгуур хангасан эсэхийг магадлах**

#### **§ 38. Худалдан авах ажиллагаанаас тендерт оролцогч ба өрсөлдөгчийг хасах**

(1) Захиалагч байгууллага нь дараахи тохиолдолд тухайн этгээдтэй нийтийн гэрээ байгуулах ёсгүй бөгөөд худалдан авах ажиллагаанаас тендерт оролцогч ба өрсөлдөгчийг хэдийд ч хасч болно. Үүнд:

1) тухайн этгээд буюу түүний хууль ёсны төлөөлөгч гэмт хэргийн бүлэглэл зохион байгуулсан хэрэгт ял шийтгэгдэж байсан эсхүл тийм бүлэглэлд хамаардаг эсхүл нийтийн худалдан авах ажиллагааны шаардлагыг зөрчсөн, мэргэжлийн ёс зүйтэй холбоотой зөрчил гаргаж байсан эсхүл луйвар буюу мөнгө угаах хэрэг үйлдэж байсан бөгөөд тэдгээр ял

шийтгэлийн талаархи мэдээлэл нь Ял Шийтгэлийн бүртгэлийн тухай хуульд зааснаар ял шийтгэлийн бүртгэлээс хасагдаагүй эсхүл оршин суугаа буюу байрлаж байгаа орны хуулийн дагуу ял шийтгэл нь хүчин төгөлдөр хэвээр байгаа;

2) тухайн этгээд нь дампуурсан буюу татан буугдаж байгаа, 28-р хэсгийн 4-р дэд хэсгийн 4-т заасан нөхцлийн дагуу бараа бүтээгдэхүүн худалдаж авснаас бусад тохиолдолд тухайн этгээдийн бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон буюу байрлаж буй орны хуулиар түүнтэй төстэй нөхцөл байдалд орсон,

3) байрлаж буй орны хуулиар албадан татан буулгах буюу түүнтэй төстэй үйл явц эхэлсэн;

4) улсад төлөх ёстой татвар, захиалагч байгууллагын байрлаж буй буюу өөрийн оршин суугаа буюу байрладаг газрын орон нутгийн татвар эсхүл нийгмийн даатгалын шимтгэл зэргийг төлөх үүргээ биелүүлээгүй эсхүл захиалагч байгууллагад холбогдох гэрчилгээг гардуулснаас хойш сүүлийн 12 сарын хугацаанд 30 хоногоос дээшхи хугацааны татвар төлөлтийн үлдэгдэлтэй,

5) нэг ижил нийтийн худалдан авах ажиллагаа буюу нэг худалдан авах ажиллагааны хүрээнд нийтийн худалдан авах ажиллагааг багц болгон хуваасан тохиолдолд нэг ижил багцад хамтарсан тендерийн санал ирүүлсэн бөгөөд түүнтэй зэрэгцэн дангаараа тендерийн санал ирүүлсэн, эсхүл өөр бусад тендерт оролцогчидтой хамтран хэд хэдэн хамтарсан тендерийн санал ирүүлсэн, эсхүл нийтийн гэрээг туслан гүйцэтгэгчийн журмаар гүйцэтгэх бусад тендерт оролцогчдыг нэрлэсэн;

6) захиалагч байгууллагаас энэхүү бүлэг буюу энэхүү бүлэгт дурдсан нөхцлүүдэд үндэслэн тавьсан шаардлагуудыг биелүүлэх үүднээс тулд хуурамч мэдээлэл өгсөн бол.

(2) Захиалагч байгууллага дараахи тохиолдолд тендерт оролцогч ба өрсөлдөгчийг худалдан авах ажиллагаанаас хасч болно. Үүнд:

1) тухайн этгээд буюу төлөөлөгч мэргэжлийн буюу албан тушаалын ёс зүйн дүрмийн заалтыг ноцтой зөрчсөн нь мэргэжлийн буюу албан тушаалын холбоодын ёс зүйн шүүхээр тогтоогдсон, эсхүл бусад ижил төстэй үндэслэлээр тогтоогдсон бол;

2) захиалагч байгууллагаас шаардсан тендерт оролцогч ба өрсөлдөгчийг худалдан авах ажиллагаанаас хасах үндэслэл байхгүйг нотолсон мэдээлэл буюу баримт бичгийг ирүүлээгүй бөгөөд тэдгээр мэдээлэл буюу баримт бичгийг нийтийн Бүртгэлээс ихээхэн зардал гаргалгүйгээр авах боломжгүй бол;

3) энэхүү хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан нөхцөл байдалд гарсан томоохон өөрчлөлтийн талаар захиалагч байгууллагад мэдэгдээгүй;

4) нэг ижил нийтийн худалдан авах ажиллагааны гэрээний баримт бичгийг

боловсруулахад оролцсон этгээд тендерийн саналыг болосвруулсан, эсхүл бусад байдлаар захиалагч байгууллагатай холбоотой бөгөөд тэрхүү этгээдийн мэдэж буй мэдээлэл түүнд бусад тендерт оролцогчдоос таатай байдал бий болгож байгаа бол;

5) сүүлийн нэг жилийн дотор ажилтан бүрт нийгмийн татвар ба нийгмийн даатгалын шимтгэлийг холбогдох салбарт тухайн улс буюу орон нутгийн хувьд дундаж цалингаас ажилтан бүрт төлдөг нийгмийн татвар ба нийгмийн даатгалын шимтгэлийн нийлбэрийн 70 хувиас доош хэмжээгээр төлсөн.

(3) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс шалгуур хангасан тухай баримт бичигтэй хамт буюу тусад нь дараахи зүйлсийг шаардаж болно. Үүнд:

1) энэхүү хэсгийн 1-р дэд хэсгийн 1-3-т дурдсан нөхцөл байдал байхгүйг бичгээр нотолсон нотолгоо ирүүлэх;

2) тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн байрлаж буй орны Татвар ба гаалийн газрын гэрчилгээ эсхүл тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн орон нутгийн эрх бүхий татварын байгууллагаас энэхүү хэсгийн 1-р дэд хэсгийн 4-т заасан нөхцөл байхгүйг нотолсон гэрчилгээ эсхүл эрх бүхий захиргааны байгууллагын тухайд тийм агуулгатай гэрчилгээ олгодоггүй бол тэрхүү байгууллагаас олгосон татварын өргүй болохыг гэрчилсэн гэрчилгээ.

(4) Захиалагч байгууллага тендерт оролцогчоос тендерийн саналын хамт нийтийн гэрээний шууд гүйцэтгэлд давхар гэрээний үндсэн дээр оролцох туслан гүйцэтгэгчдэд энэхүү хэсгийн 1, 2-р дэд хэсэгт заасан үндэслэл байхгүйг нотолсон нотолгоог бигээр ирүүлэхийг шаардаж болно.

(5) Захиалагч байгууллага энэхүү хэсгийн 1-2-р дэд хэсэгт заасан үндэслэл тендерт оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчид байгаа хэмээн баттайгаар эргэлзэж байгаа бол тендерт оролцогч, өрсөлдөгчөөс ял шийтгэлийн бүртгэлээс дурдсан үндэслэл байхгүйг нотолсон холбогдох мэдэгдэл, эсхүл тендерт оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчийн байрлаж буй улсын шүүх буюу захиргааны байгууллагаас гаргасан адилтгах баримт бичиг, эсхүл эрх бүхий захииргааны байгууллагаас уг зорилгоор олгосон бусад гэрчилгээ, эсхүл тендерт

оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчийн зүгээс дээр дурдсан үндэслэл байхгүйг нотолсон нотолгоо авахаар холбогдох захиргааны байгуулагад хандахыг зөвшөөрсөн бичгэн зөвшөөрөл зэргийг ирүүлэхийг шаардаж болно.

Тендерт оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчийн байрлаж буй улс тийм баримт бичиг гаргаж өгөөгүй бол түүнийг тендерт оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгч буюу түүний төлөөлөгч тангараг өргөн мэдүүлсэн мэдүүлэг, эсхүл тендерт оролцогч, өрсөлдөгч буюу тендерт оролцогчийн туслан гүйцэтгэгчийн байрлаж буй улсын хуульд нийцүүлэн эрх бүхий хууль зүйн буюу захиргааны байгууллага буюу нотариат, эсхүл албан тушаалын буюу мэргэжлийн холбоодын өмнө мэдүүлгээр орлуулж болно.

(6) Захиалагч байгууллага тендерт оролцогчид болон хамтарсан өрсөлдөгчдөөс шалгуур хангасан тухай баримт бичгээ ирүүлэхдээ тэдгээрийн төлөөлөгчдөд эрх олгосон нотариатын баталгааг хамт шаардаж болно.

(7) Захиалагч байгууллага нь тендерт оролцогч буюу өрсөлдөгчийг энэхүү хэсэгт заасан үндэслэлээр худалдан авах ажиллагаанаас хасахдаа үндэслэл бүхий холбогдох шийдвэрийг бичгээр гаргана.

### **§ 39. Тендерт оролцогч ба өрсөлдөгчийн шалгуур хангасан эсэхийг нягтлах**

(1) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгч гэрээний мэдэгдэлд дурдсан шалгуурт тэнцэх эсэх техникийн болон эдийн засгийн нөхцөл байдлыг нягтлан шалгах ёстой. Шалгуурт тэнцэхэд тавигдах шаардлага нь тендерт оролцогч буюу өрсөлдөгч нийтийн гэрээг бүрэн гүйцэтгэх чадавхийг нотлоход хангалттай байх ёстой бөгөөд нийтийн гэрээний объект болох бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын шинж чанар, хэмжээ болон зорилгыг зохих ёсоор харгалзан үзсэн байх ёстой.

(2) Захиалагч байгууллага нь худалдан авах ажиллагааны хүрээнд нийтийн худалдан авах ажиллагааг багцад хуваасан бөгөөд өөр өөр багцад өөр өөр шалгуур тогтоосон бол гэрээний мэдэгдэлд тусад нь заасан шалгуур бүхий тендерийн санал ирүүлсэн буюу худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлт гаргасан тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн эдийн засгийн ба санхүүгийн нөхцөл байдал хийгээд техникийн болон мэргэжлийн чадавхи шаардлага хангаж байгаа эсэхийг тусад нь нягтлан шалгана. Захиалагч байгууллага нэгээс илүү багц бүхий худалдан авах ажиллагаанд тендерийн санал буюу

оролцох хүсэлт гаргасан тендерт оролцогч буюу өрсөлдөгчдөд зориулан багцийн төсөвт өртгийн үзүүлэлтүүдийн нийлбэрийг харгалзсан ур чадварын илүү өндөр шалгуур тогтоож болно.

(3) Тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн эдийн засгийн ба санхүүгийн нөхцөл байдал хийгээд техникийн болон мэргэжлийн чадавхи гэрээний мэдэгдэлд заасан шалгуурыг хангахгүй байгаа нь илэрвэл захиалагч байгууллага худалдан авах ажиллагааны хүрээнд тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн шалгуур хангаж байгаа эсэхийг нягтлах эрхтэй бөгөөд тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн шалгуур хангаж буй эсэх талаар шинээр шийдвэр гаргаж, тендерт оролцогч буюу өрсөлдөгчийг шалгаруулалгүй үлдээж болно.

(4) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс шалгуур хангаж байгаа талаар ирүүлсэн баримт бичгийн агуулгыг тайлбарлахыг шаардах, эсхүл нэмэлт баримт бичиг ирүүлэхийг шаардаж болно.

(5) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгчийг энэхүү хуулийн 4-р зүйлийн дагуу өмнө нь нийтийн гэрээ байгуулж байгаагүй гэсэн үндэслэлээр шалгуур хангаагүй гэж үлдээж болохгүй.

(6) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн шалгуур хангасан буюу хангаагүй талаар үндэслэлтэй шийдвэрийг бичгээр гаргана.

(7) Шалгуур хангаагүй тендерт оролцогч буюу өрсөлдөгч худалдан авах ажиллагаанд үргэлжлүүлэн оролцож болохгүй.

#### **§ 40. Тендерт оролцогч болон өрсөлдөгчийн эдийн засгийн ба санхүүгийн нөхцөл байдал**

(1) Тендерт оролцогч болон өрсөлдөгчийн эдийн засгийн ба санхүүгийн нөхцөл байдал шалгуурт нийцэж байгаа эсэхийг нягтлахын тулд захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд тодорхойлсон доорхи нэг буюу хэд хэдэн баримт бичгийг шаардаж болно.

Үүнд:

1) тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн эзэмшилд байгаа, нийтийн гэрээг гүйцэтгэх баталгаа болсон санхүүгийн арга хэрэгслийг нотлох банкны холбогдох мэдэгдлүүд буюу захиалагч байгууллагын хүлээн зөвшөөрсөн холбогдох бусад баримт бичиг;

2) тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн байрлаж буй улсын хууль тогтоомжийн дагуу жил бүрийн тайлан нь олон нийтэд нээлттэй бол 3 жил хүртэлх хугацааны жилийн тайлан ба жилийн тайлангийн хэсэг;

3) тэдгээр нь байгаа эсэхээс хамаарч 3 хүртэл жилийн хугацаан дахь тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн бизнесийн бүхий л үйл ажиллагааны цэвэр борлуулалтын тухай мэдээлэл, эсхүл нийтийн гэрээ буюу нийтийн гэрээний объектод хамаарах салбарын цэвэр борлуулалтын тухай мэдээлэл.

(2) Захиалагч байгууллага нь тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрчилгээ буюу захиалагч байгууллагын хүлээн зөвшөөрсөн холбогдох бусад баримт бичгийг шаардаж болох бөгөөд тэдгээр нь тендерт оролцогч буюу өрсөлдөгч нь нийтийн гэрээний болзошгүй зөрчлөөс үүдэн гарч болох хохирлыг нөхөн төлөх арга хэрэгсэлтэй болохыг, эсхүл тэдгээр хохирлыг хүлээж авах боломжтой болохыг харуулна.

(3) ) Шаардлагатай бол тендерт оролцогч буюу өрсөлдөгчид шалгуур хангасан гэдгээ нотлохын тулд тэд тухайн нийтийн гэрээний гүйцэтгэлийн хүрээнд эдийн засаг болон санхүүгийн нөхцөл байдалд тавигдах шаардлагуудыг хангасан гэдгээ өөрсдийн үзүүлэлтүүдээс гадна өөр этгээдийн арга хэрэгсэлд үндэслэн нотлож болно. Чингэхдээ уг этгээд нь нийтийн гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай арга хэрэгслийг эзэмшиж байгаа бөгөөд нийтийн гэрээний гүйцэтгэлийг хангахын тулд шаардлагатай бол нийтийн гэрээний объектын дагуу тендерт оролцогч буюу өрсөлдөгч нь тухайн этгээдийн дээрхи арга хэрэгслийг ашиглаж болох тухай захиалагч байгууллагад зохих хэлбэрээр нотолно.

(4) ) Хамтарсан тендерт оролцогчид болон хамтарсан өрсөлдөгчид эдийн засаг болон санхүүгийн нөхцөл байдлын шалгуурт тавигдах шаардлагуудыг хангасан гэдгээ нотлохдоо нийлбэр үзүүлэлттүүдийн тухайд бүх хамтарсан тендерт оролцогчид болон хамтарсан өрсөлдөгчдийн нийлбэр үзүүлэлттүүдийг ашиглана.

(5) Тендерт оролцогч буюу өрсөлдөгч нь гэрээний мэдэгдэлд заасан шаардлагатай баримт бичгийг хүндэтгэх шалгаанаар захиалагч байгууллагад ирүүлэх боломжгүй бол гагцхүү бусад тендерт оролцогч буюу өрсөлдөгчтэй харьцуулахад таатай нөхцөл олж авахгүй тохиолдолд эдийн засаг болон санхүүгийн нөхцөл байдлаа захиалагч байгууллагын хүлээн зөвшөөрсөн баримт бичигт тодорхойлж болно.

#### **§ 41. Тендерт оролцогчид болон хамтарсан өрсөлдөгчдийн техникийн ба мэргэжлийн чадавхи**

(1) Тендерт оролцогчид болон хамтарсан өрсөлдөгчдийн техникийн ба мэргэжлийн чадавхи нь шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлахын тулд



захиалагч байгууллага үйлчилгээний шинж чанар, ашиглалтын арга барил, эсхүл нийтийн гэрээний үндсэн дээр гэрээ байгуулсан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил болон худалдан авсан бараа бүтээгдэхүүн зэргийн талаар дараахи нэг буюу хэд хэдэн төрлийн мэдээлэл, баримт бичгийг ирүүлэхийг шаардаж болно. Үүнд:

- 1) захиалагч байгууллагын тодорхойлсон шаардлагын дагуу өртөг, хугацаа, газар зэргийг тусгасан сүүлийн 5 жилд явуулсан нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын жагсаалт, түүний дотор нийтийн худалдан авах ажиллагааны гэрээгээр гүйцэтгэсэн ажил болон тэдгээрийг байгуулсан гэрээний нөхцлүүд болон ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн сайн практикийн дагуу гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон гэрчилгээ.
- 2) сүүлийн 3 жил хүртэл хугацааны нийлүүлэлтийн өртөг, байгуулсан хугацаа болон гэрээний бусад оролцогчдын талаархи мэдээлэл зэрэгт үндэслэн захиалагч байгууллагын тогтоосон шаардлагын дагуу нийлүүлэх үндсэн бараа бүтээгдэхүүний жагсаалт;
- 3) тендерт оролцогч буюу өрсөлдөгчдийн техникчид ба техникийн байгууллагын таалархи мэдээлэл, ялангуяа тендерт оролцогч буюу өрсөлдөгч компаний ажилтан байх эсэх, эсхүл туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаагаас үл хамааран чанарын хяналтыг хариуцаж байгаа ажилтнуудын мэдээлэл; ажлын гэрээний тухайд нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа боловсон хүчин болон техникийн байгууллагын талаархи мэдээлэл;
- 4) ажлын чанарт хяналт тавих, дүн шинжилгээ хийх зорилгоор ашиглаж байгаа арга хэрэгсэл, арга хэмжээний тодорхойлолт, тэрчлэн тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн зүгээс чанарыг хангах зорилгоор ашиглаж байгаа техникийн тоног төхөөрөмж;
- 5) тендерт оролцогч буюу өрсөлдөгч, тэдгээрийн удирдах ажилтнууд холбогдох нийтийн өмчийн барилга байгууламжийн ажилд үйлчилгээ үзүүлэх болон түүний удирдан явуулах этгээдүүдийн туршлага, боловсрол, мэргэжлийн ур чадварын тухай мэдээлэл;
- 6) ажлын буюу үйлчилгээний гэрээний тухайд хэрэв боломжтой бол нийтийн гэрээг гүйцэтгэхэд ашиглах хүрээлэн буй орчны менежментийн арга хэмжээ;
- 7) үйлчилгээ буюу ажлын гэрээний тухайд тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн ажилтнууд, удирдлагын зөвлөлийн гишүүдийн дундаж тоо болон сүүлийн 3 жилийн турш бусад гэрээний үндсэн дээр тухайн компанид ажиллаж байгаа хүмүүсийн тоо;
- 8) тендерт оролцогч буюу өрсөлдөгч нийтийн гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, техникийн тоног төхөөрөмж байгааг нотолсон нотолгоо,

эсхүл шаардлагатай тоног төхөөрмжийг олж авах, ашиглах тухай бичгээр гаргасан холбогдох мэдэгдэл;

9) үйлчилгээний гэрээний тухайд тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс туслан гүйцэтгэх гэрээ байгуулж болзошгүй нийтийн гэрээний хувь хэсгийг тодорхой заах;

10) нийтийн гэрээний объект болох бараа бүтээгдэхүүний загвар, тодорхойлолт буюу гэрэл зураг, хэрэв шаардлагатай бол тэдгээрийн жинхэнэ гэдгийг нотлох;

11) техникийн шалгалт ба хяналтын байгууллагуудаас бараа бүтээгдэхүүн техникийн дүрэм журам буюу стандартад нийцэж байгааг нотолсон гэрчилгээ.

(2) Нийтийн гэрээний төсөвт өртөг олон улсын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан тохиолдолд захиалагч байгууллага энэхүү хэсгийн 1-р дэд хэсгийн 1, 2-т заасан мэдээлэл гэрээний мэдэгдэлд заавал байх ёстойг ямагт шаардах эрхтэй.

(3) Нийтийн гэрээний үндсэн дээр явуулах үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу тусгай шаардлага тавигдах ёстой бол захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгч тийм үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл буюу бүртгэлтэй эсэх, байрлаж буй улсын хууль тогтоомжид заасан холбогдох байгууллагад харьяалагддаг эсэхийг хянах ёстой бөгөөд хэрэв шаардлагатай бол, тэдгээр мэдээллийг захиалагч байгууллагад ихээхэн зардал учруулалгүйгээр Бүртгэлээс авах боомжгүй тохиолдолд тэдгээрийг нотолсон гэрчилгээ ирүүлэхийг шаардаж болно.

(4) Үндсэн гэрээг зохих ёсоор хэрэгжүүлэх талаар захиалагч байгууллагын хүсэлтээр 1-р дэд хэсгийн 2-т заасан жагсаалтад дараахи зүйлийг хавсаргана. Үүнд:

1) гэрээний нөгөө оролцогч нь энэхүү хуулийн 10-р хэсгийн 1-р дэд хэсгийн 1-3-т дурдсан захиалагч байгууллага байгаа тохиолдолд гэрээний нөгөө оролцогчийн олгосон гэрчилгээ;

2) гэрээний нөгөө оролцогч нь хувийн эрх зүйгээр зохицуулагдах этгээд буюу хувь хүн байгаа тохиолдолд нөгөө оролцогчийн нотолгоо, эсхүл тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн бичгээр гаргасан нотолгоо.

(5) нийтийн гэрээний объект боох бараа бүтээгдэхүүн буюу үйлчилгээ нь нарийн төвөгтэй буюу тусгай зориулалттай бол нийлүүлэгч буюу үйлчилгээ үзүүлэгчийн харьяалах захиалагч байгууллага буюу эрх бүхий албан ёсны байгууллага үйлдвэрлэлийн боломжийн талаар захиалагч байгууллагатай байгуулсан хэлэлцээр, эсхүл тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн техникийн чадварыг магадлан шалгах бөгөөд хэрэв

шаардлагатай бол шинжлэх ухааны ба судалгааны ажил явуулах боломж, мөн мөрдөгдөж буй чанарын хяналтын арга хэмжээг нягтлан шалгана.

(6) Тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн ур чадварыг шалгах шаардлагатай бөгөөд тохиромжтой бол тендерт оролцогч буюу өрсөлдөгч тухайн нийтийн гэрээг тухайн этгээдтэй эрх зүйн ямар холбоотойгоос үл хамааран, бусад этгээдийн арга хэрэгсэл, арга хэмжээ буюу мэргэжилтнүүдийн холбогдох үзүүлэлтүүдийн үндсэн дээр гүйцэтгэхэд шаардлагатай чадварын шалгуурын хүрээнд тавигдаж буй техникийн болон мэргэжлийн чадвар эзэмшиж буй гэдгээ нотлож болно. Энэ зорилгоор захиалагч байгууллагын хүлээн зөвшөөрөхүйц арга хэлбэрээр тухайн этгээд холбогдох арга хэрэгсэл, арга хэмжээ буюу мэргэжилтнүүдтэй бөгөөд тендерт оролцогч буюу өрсөлдөгч шаардлагатай тохиолдолд нийтийн гэрээг хэрэгжүүлэхийн тулд тэдгээрийг ашиглах боломжтой гэдгээ нотлох ёстой.

(7) Хамтран тендерт оролцогчид буюу өрсөлдөгчид нь тухайн шалгуурын онцлогоос шалтгаалан хэрэв боломжтой бол тэдэнтэй хамтран тендерт оролцож байгаа буюу өрсөлдөж байгаа этгээдүүдийн техникийн болон мэргэжлийн чадавхи ур чадварын шаардлагад нийцэж байгаад найдаж болно.

(8) Нийлүүлэлтийн гэрээний объект нь бараа бүтээгдэхүүнээс гадна тэдгээрийг хүргэх буюу суурилуулах, эсхүл холбогдох үйлчилгээ буюу нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил байгаа тохиолдолд захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгч эсхүл энэхүү хэсгийн 6-р дэд хэсэгт дурдсан бусад этгээд тэдгээр үйлчилгээ буюу ялангуяа тухайн этгээдийн техникийн болон мэргэжлийн чадварт хамаарах нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлыг явуулах шалгуур хангасан эсэхийг магадлан шалгана.

(9) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд тендерт оролцогч буюу өрсөлдөгч чанарын баталгааны тодорхой стандарт хангасан тухай хараат бус байгууллагаас олгосон гэрчилгээ ирүүлэхийг шаардсан бол тэр нь Европын стандартын цувралын гэрчилгээнд нийцсэн байгууллагуудаас баталсан холбогдох Европын стандартад үндэслэсэн чанарын баталгааны системд нийцсэн байна. Захиалагч байгууллага бусад Гишүүн улсын байгууллагуудын дүйцэх гэрчилгээг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс ирүүлсэн чанарын баталгааны дүйцэх арга хэмжээг зөвшөөрнө.

(10) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд энэхүү хэсгийн 1-р дэд хэсгийн 6-д заасан хүрээлэн буй орчны менежментийн арга хэмжээний жагсаалт ирүүлэхийг шаардсан бол

тэр нь Европын Холбооны Есо-Менежмент ба Аудио Схем (EMAS) эсхүл гэрчилгээний асуудлаархи холбогдох Европын буюу олон улсын стандартад үндэслэсэн ЕХ-ны хууль тогтоомж, эсхүл холбогдох байгууллагаас баталсан Европын буюу олон улсын стандартад үндэслэсэн хүрээлэн буй орчны менежментийн стандарт зэргийг баримтална.

Захиалагч байгууллага ЕХ-ны бусад гишүүн улсын байгууллагуудын дүйцэх гэрчилгээг хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс ирүүлсэн чанарын баталгааны дүйцэх арга хэмжээг зөвшөөрнө.

#### **§ 42. Зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалт ба тэдгээрийн баталгаажуулалт**

(1) Зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтад бүртгэгдсэн буюу зөвшөөрөл авсан компани хэмээн батлагдсан этгээд худалдан авах ажиллагааны шалгаруулалтад оролцох чадавхиа нотлож зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтыг хариуцагчийн олгосон гэрчилгээг магадлан итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын жагсаалт буюу гэрчилгээнд зөвшөөрөгдсөн компани хэмээн бүртгүүлэхээр ирүүлж болно. Дурдсан гэрчилгээнд ямар мэдээллийн үндсэн дээр уг этгээдийг жагсаалтад бүртгэсэн буюу тухайн этгээдэд гэрчилгээ олгосон, жагсаалтад олгосон ангилал зэргийн тухай мэдээллийг зааж өгнө.

(2) Эстони буюу Европын Холбооны бусад гишүүн улсад зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтыг хариуцагчийн олгосон, тухайн этгээдийг зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтад бүртгэсэн тухай буюу гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагын олгосон гэрчилгээ нь 38-41-р зүйлд заасан тухайн этгээдэд гэрчилгээ олгох буюу жагсаалтад бүртгэх үндэс болсон мэдээллийн тухайд тухайн этгээд чадварын шаардлага хангаж байгааг захиалагч байгууллагад нотолно. Дурдсан нотолгоо буюу гэрчилгээ нь тэдгээрийг олгох үндэслэл болсон шаардлага нь захиалагч байгууллагаас тавьсан шаардлагатай тэнцүү буюу түүнээс өндөр тохиолдолд тухайн этгээд захиалагч байгууллагаас тавьсан шаардлагыг хангаж байгааг нотолно.

(3) Хувь хүний жагсаалтад бүртгэгдсэн эсвэл гэрчилгээтэй эсэх зэрэг мэдээллээс гадна захиалагч байгууллага нь нэр дэвшигч эсвэл тендерт оролцогчоос энэхүү хэсгийн 4-р дэд хэсэгт заасанчлан оршин суугаа орон нутгийн, үндэсний болон орон нутгийн татварын болон нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тухай гэрчилгээнээс гадна нэмэлт гэрчилгээ шаардаж болно.

(4) Захиалагч байгууллага нь энэхүү хэсгийн 2 ба 3-р дэд хэсгийг зөвхөн Европын холбооны гишүүн оронд байрлаж байгаа тендерт оролцогч болон нэр дэвшигчдийн тухайд болон зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтыг хадгалах болон батлах журамд ашиглаж болно.

(5) Бүгд Найрамдах Улсын Засгийн Газар нь тодорхой чиглэлээр зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтыг болон Эстонийн холбогдох салбарын асуудал эрхэлсэн сайдын зөвшөөрөлтэй компаниудын гэрчилгээжүүлэх журам бий болгох, хадгалах, шинэчлэнэ.

(6) Тодорхой чиглэлээр зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалт хариуцагч нь холбогдох салбарыг хариуцсан яам байна. Бүгд Найрамдах Улсын Засгийн Газрын зөвшөөрлөөр тухайн яам нь зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтыг хариуцах эрхийг өөр хууль ёсны этгээдэд захиргааны гэрээгээр олгож болно.

(7) Зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалт хариуцагч болон батлагдсан үйл ажиллагааны албан ёсны жагсаалтын гэрчилгээ, түүний баталгаажуулалт олгох эрх бүхий байгууллага нь үйл ажиллагааны албан ёсны жагсаалтад орох үйл ажиллагаанаас болон гэрчилгээ олгох болон сунгахад төлбөр шаардах эрхтэй. Төлбөрийн хэмжээ нь жагсаалт хариуцагчийн үйл ажиллагаатай холбоотой бодит өртөг дээр эсхүл Бүгд Найрамдах Улсын Засгийн газар нь тухайн баталгаажуулалтын байгууллагыг байгуулсан зэрэг дээр тулгуурлана.

(8) Батлагдсан үйл ажиллагааны энэ актыг зөвхөн албан ёсны жагсаалтад бүртгэх нөхцөл байдал бий болгох болон энэхүү хуулийн 38-41-р зүйлд заасан баталгаажуулах шаардлагыг харгалзан үзэх ёстой.

(9) Европын холбооны бусад гишүүн улсын зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалтад бүртгэлтэй хувь хүмүүсийн оршин суугаа оронд ямарваа гэрчилгээний бүртгэл хийхэд Эстони улсад бүртгэл хийлгэсэн хүмүүсээс шаардсан бичиг баримтаас өөр нэмэлт мэдээлэл, гэрчилгээ шаардахгүй.

(10) Зөвшөөрөлтэй компаниудын албан ёсны жагсаалт, эсхүл зөвшөөрөлтэй компаниудын гэрчилгээ, эрх бүхий баталгаажуулалтын байгууллагын хариуцагч нь аливаа компанийг баталгаажуулалтын бүртгэлд бүртгэхээс үндэслэлгүйгээр татгалзаж үл болно.

(11) Энэхүү хуульд зааснаар эрх бүхий баталгаажуулалтын байгууллага нь Европын баталгаажуулалт стандартад нийцсэн байгууллага байна.

## **Бүлэг 4**

### **Тендерийн санал ба түүнийг ирүүлэх, нээх ба үнэлэх**

#### **§ 43. Тендерийн санал**

(1) Тендерийн санал гэдэг нь нийтийн гэрээ байгуулах эрх авахаар тендерт оролцогчийн илэрхийлсэн хүсэл бөгөөд тендерт оролцогчийн хувьд тендерийн санал ирүүлснээс хойш дор хаяж гэрээний баримт бичигт тогтоосон тендерийн саналын хүчинтэй хугацаа дуусах хүртэл заавал биелэгдэх хүчинтэй байна.

(2) Тендерийн санал нь гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичигт заасан нөхцлүүд, тэрчлэн хэрэв энэхүү хуульд заасан журмын дагуу тусад нь тендерийн урилга илгээсэн бол тэрхүү урилгад заасан нөхцлүүдийг мөрдөх ёстой.

(3) Тендерт хамтран оролцогчдын тендерийн саналд тендерт хамтран оролцогчид нийтийн гэрээний гүйцэтгэлд хамтран хариуцлага хүлээх нотолгоог багтаана.

(4) Тендерийн санал нууц байна. Тендерийн саналд тусгагдсан мэдээллийг зөвхөн энэхүү хуульд заасан тохиолдлууд болон хүрээнд задруулж болно.

#### **§ 44. Тендерийн санал ирүүлэх**

(1) Тендерийн саналыг бичгийн хэлбэрээр битүүмжилж, тэмдэглэгдсэн дугтуйнд эсхүл цахим хэлбэрээр энэхүү хууль болон түүнд үндэслэн гаргасан хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн ирүүлнэ.

(2) Тендерт оролцогч нь тендерийн санал ирүүлэх өдрөөс өмнө холбогдох мэдэгдлийг тендертэй ижил хэлбэрээр захиалагч байгууллагад ирүүлэх замаар тендерийн саналаа буцаан татаж болно.

(3) Хэрвээ тендерт оролцогч нь тендерийн санал ирүүлэх хугацаанд шинэ тендерийн санал ирүүлбэл уг оролцогчийн өмнө нь өгсөн тендерийн саналууд нь энэ хэсгийн 2-р дэд хэсэгт заасан мэдэгдлийг ирүүлэхээс нааш хүчингүй болохгүй.

(4) Захиалагч байгууллага өөр шийдлүүд ирүүлэх боломж өгсөн бол тендерт оролцогч өөр шийдэл бүхий тендерийн санал ирүүлж болно.

(5) Тендерт оролцогч нь хэрэв тендерийн санал дангаараа ирүүлж байгаа, эсхүл өөр тендерт оролцогчтой хамтран тендерийн санал ирүүлж байгаа бол хамтарсан тендерийн санал ирүүлж болохгүй. Тендерт оролцогч нь бусад тендерт оролцогчдод тендерийн нийтийн гэрээнд өөрийг нь туслан гүйцэтгэгчээр нэрлэхийг зөвшөөрсөн бол хамтарсан тендерийн санал ирүүлж болохгүй.

(6) Захиалагч байгууллага нь тендер хүлээн авсан тухай баталгааг тендерт оролцогчийн хүсэлтийн дагуу нэн даруй ирүүлнэ.

#### **§ 45. Тендерийн саналын хүчинтэй хугацааны сунгалт**

(1) Тендерт оролцогч нь захиалагч байгууллагын бичгээр ирүүлсэн саналд үндэслэж тендерийн хүчинтэй хугацааг сунгуулж болно.

(2) Захиалагч байгууллага нь худалдан авах ажиллагаа тухайн мөчид дуусгавар болоогүй тохиолдолд тендерийн хүчинтэй хугацаа дуусахаас дор хаяж 10 хоногийн өмнө энэ хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан саналаа ирүүлэх үүрэгтэй.

#### **§ 46. Тендерийн саналыг нээх**

(1) Тендерийн саналыг гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичиг, эсхүл захиалагч байгууллагын тендерийн урилгад заасан газар болон цагт нээнэ.

(2) Тендерийн саналыг нээхдээ, захиалагч байгууллага нь ирүүлсэн тендерийн саналууд гэрээний баримт бичигт нийцэж байгаа эсэхийг хянах ёстой ба хэрвээ өрсөлдөөнт хэлцэл явуулсан тохиолдолд бичиг баримтын жагсаалт болон тендерт оролцогчдын нэр бүхий тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд түүнд ирүүлсэн тендерийн бүртгэлийн код, тендерийн саналын өртөг, түүний дотор тендерийн саналыг үнэлэхэд харгалзан үзэх тохиолдолд тендерийн хэсэгчилсэн төлбөр, тэрчлэн тендерийн саналыг үнэлэх шалгуурт нийцсэн тендерийн саналын тоон үзүүлэлтийн өртөг зэргийг багтаана. Тэмдэглэлд гэрээний баримт бичиг эсхүл тендер ирүүлэх саналд заасан нөхцлүүдийг дагаж мөрдөөгүй тендерийн саналуудын талаар болон нээх үед нотлогдсон тухайн нөхцөл байдалд үндэслэсэн дагаж мөрдөөгүй шалтгааны талаар мэдээллийг тусгана.

(3) Захиалагч байгууллага нь тендерийн саналын нээлтийн тухай тэмдэглэлийн хуулбарыг тендер нээснээс ажлын 3 өдрийн дотор бүх тендерт оролцогчдод дамжуулна. Хэрвээ энэ нь тендерт оролцогч нарт худалдан авалтын үйл явцад гарсан шийдвэрүүдийн талаар мэдээлэл дамжуулах бол худалдан авалтын үйл явцыг дуусгавар болгоход үндэслэсэн шийдвэр, эсхүл энэхүү хуулийн 54-р хэсгийн 10-р дэд хэсэгт зааснаар, мөн өрсөлдөгчид гэрээний баримт бичигт ийм боломж байгаа талаар мэдэгдсэн эсхүл тендерт ирүүлсэн саналдаа тусгасан бол захиалагч байгууллага нь тендер нээсэн тухай тэмдэглэлийг тендерийг амжилттай гэж зарласан шийдвэрийн мэдэгдлийн хуулбар эсхүл ханган нийлүүлэх үйл явцыг дуусгавар болгох шийдвэрт үндэслэсэн мэдэгдлийн хамтаар бүх тендерт оролцогч нарт хүргүүлж болно.

(4) Захиалагч байгууллага нь тендерт оролцогчид эсхүл тэдний эрх бүхий төлөөлөгчдийг тендерийн саналыг нээх үеэр байлцах нөхцлийг хангана.

(5) Захиалагч байгууллага нь тендерийн саналыг нээхдээ тендерт оролцогчдын бизнесийн нууцыг зөрчих, эсхүл харилцан өрсөлдөөнд хор уршиг учруулах тендерийн агуулгыг задруулж болохгүй.

#### **§ 47. Тендерийн санал шаардлагад нийцэж буй эсэхийг магадлах**

(1) Захиалагч байгууллага нь 46-р хэсэгт заасан журмын дагуу шаардлага хангасан тендерт оролцогчдоос ирүүлсэн тендерийн санал гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичгийн нөхцлүүдэд нийцэж байгаа эсэхийг болон захиалагч байгууллага энэ хуульд заасан журмын дагуу тендерийн салангид урилга явуулсан тохиолдолд, уг саналд тусгагдсан нөхцлүүдэд нийцэж байгаа эсэхийг магадлан шалгах бөгөөд тендерийн саналыг шаардлага хангасан тухай эсхүл тендерийн саналаас татгалзсан тухай үндэслэлтэй шийдвэр бичгээр гаргана.

(2) Захиалагч байгууллага нь гэрээний мэдэгдэл эсхүл гэрээний баримт бичгийн нөхцөл эсхүл захиалагч байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу тендерийн салангид урилга явуулсан тохиолдолд уг саналын нөхцөлд нийцээгүй тендерийн саналаас татгалзана. Захиалагч байгууллага нь дурдсан нөхцлүүдээс илт хазайгаагүй тохиолдолд тендерийн саналыг тохиромжтой гэж үзсэнээ зарлаж болно.

(3) Захиалагч байгууллага нь, тухайлбал, тендер нь 31-р хэсгийн 2-р дэд хэсгийн 9-р заалтад заасан шаардлагатай нөхцлийг агуулаагүй тохиолдолд уг тендерийн саналаас татгалзана.

(4) Захиалагч байгууллага нь энэхүү хуулийн 33-р хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтыг авч үзэж байгаа бол тендерт оролцогч нь ямар нэг зохистой гэрчилгээ ашиглан зөвшөөрч болохуйц арга замаар захиалагч байгууллагад батласан мөн санал болгосон шийдэл нь техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг хангасан тохиолдолд, захиалагч байгууллага нь нийтийн хангамж, үйлчилгээний гэрээ олгохдоо дагаж мөрдөөгүй шалтгаанаар тендерт татгалзсан хариу өгөхгүй.

(5) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээний объектын гүйцэтгэл эсхүл чиг үүргийн шаардлагад тулгуурлан энэхүү хуулийн 33-р хэсгийн 3-р дэд хэсэгт заасан журмын дагуу нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн тохиолдолд тендерийн



саналд татгалзсан хариу өгөхгүй. Энэ тохиолдолд санал болгож буй нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил болон үйлчилгээ нь нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтын үндэс болсон гүйцэтгэл ба чиг үүргийн шаардлагыг зохицуулсан 33-р хэсгийн 1-р дэд хэсгийн 1-7-р заалтад нийцэж байгаа бөгөөд тендерт оролцогч нь үүнийг захиалагч байгууллагад хүлээн зөвшөөрч болохуйц тохиромжтой хэлбэрээр зохих гэрчилгээг үзүүлж нотлох ёстой.

(6) Захиалагч байгууллага нь нийтийн гэрээний объектын техникийн тодорхойлолтод энэхүү хуулийн 33-р хэсгийн 6-р дэд хэсэгт заасан урьдчилсан нөхцлийг зааж өгсөн тохиолдолд эко-шошгын техникийн тодорхойлолтын суурь болсон хүрээлэн буй орчинд нөлөө үзүүлэх хүчин зүйлсийг мөрдөж байгааг нотолсон холбогдох бусад нотолгоог хүлээн авна.

(7) Энэ хэсгийн 4-6-р дэд хэсэгт зааснаар зохих ёсны гэрчилгээ гэдэг нь бүтээгдэхүүний техникийн баримт бичиг эсхүл эрх бүхий байгууллагын туршилтын протокол байж болно.

(8) Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтын худалдан авах ажиллагааг багцад хуваасан тохиолдолд захиалагч байгууллага нь багц бүрт ирүүлсэн тендерийн санал гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичигт заасан нөхцлийг хангаж байгаа эсэхийг хянах бөгөөд захиалагч байгууллага энэхүү хульд заасан журмын дагуу тусад нь тендерийн урилга илгээсэн бол уг саналд тусгасан нөхцлийг хангаж байгаа эсэхийг хянан үзнэ.

(9) Тендерийн саналдаа татгалзсан хариу авсан тендерт оролцогч цаашдын худалдан авах ажиллагаанд оролцохгүй.

(10) Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтыг нэг худалдан авах ажиллагааны хүрээнд олон багцад хуваасан, тендерт оролцогч нь нэгээс илүү багцад тендерийн санал ирүүлсэн, мөн зарим багцад ирүүлсэн тендерийн санал нь тохиромжтой гэж зарлагдсан тохиолдолд, тендерт оролцогч нь эдгээр багцад хамаарах цаашдын худалдан авах ажиллагаанд оролцно.

(11) Тендерт оролцогч нь нийтийн худалдан авалт болон нийтийн худалдан авалтын нэг багцад нэгээс олон тендерийн санал ирүүлсэн бөгөөд тэрхүү нийтийн худалдан авах ажиллагаа буюу зарим багцад ирүүлсэн аль нэг тендерийн санал тохиромжтой гэж зарлагдсан тохиолдолд тендерт оролцогч нь тийнхүү тохиромжтой гэж зарлагдсан тендерийн саналаараа цаашдын худалдан авах ажиллагаанд оролцоно.

#### **§ 48. Хэт бага өртөгтэй тендерийн санал**

(1) Захиалагч байгууллага нь тендерийн саналын өртөг нь нийтийн гэрээний төсөвт өртгөөс хэт бага гэдгийг мэдсэн тохиолдолд захиалагч байгууллага нь тендерт оролцогчоос бичгээр тайлбар шаардах ёстой. Тендерт оролцогч нь холбогдох шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор захиалагч байгууллагад бичгээр тайлбар ирүүлэх үүрэгтэй.

(2) Энэ хэсгийн 1-р дэд хэсэгт дурдсан тендерийн саналын хэт бага өртгийг дараахи байдлаар зөвтгөж болно. Үүнд:

1) Барилгын аргачлал, үйлдвэрлэлийн үйл явц, эсхүл үйлчилгээний эдийн засгийн тооцоо;

2) Тендерт оролцогчийн сонгосон техникийн шийдэл, эсхүл тендерт оролцогчдын нийтийн гэрээг гүйцэтгэх онцгой тааламжтай нөхцөл

3) Нийтийн өмчийн барилга байгууламжийн ажил, бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээний онцгой шинж чанар;

4) нийтийн гэрээг гүйцэтгэх явцад ажлын нөхцөл байдлыг зохицуулсан нөхцлүүдийн үндсэн дээр ажилтнуудыг хамгаалах;

5) тендерт оролцогчид төрөөс тусламж авах боломжтой байх.

(3) Захиалагч байгууллага нь ирүүлсэн тайлбарыг магдлан шалгах ба шаардлагатай бол тендерт оролцогчтой зөвлөлдөн, нотлох баримтыг үнэлж дүгнэх ёстой. Захиалагч байгууллага тендерийн саналын үнийг хэт бага байна гэж үзсээр байгаа эсхүл тендерт оролцогч нь шаардагдсан тайлбарыг ирүүлээгүй тохиолдолд захиалагч байгууллага нь бичгээр гаргасан шийдвэрт үндэслэн тендерийн саналаас татагалзаж болно.

(4) Захиалагч байгууллага нь тендерт оролцогч төрөөс тусламж авснаар тендерийн саналын үнийг хэт бага гэж тодорхойлсон тохиолдолд гагцхүү тендерт оролцогч төрөөс авсан тусламж нь хууль тогтоомжид нийцэж байгаа гэдгийг баталж чадаагүй тохиолдолд тендерийн саналаас татгалзаж болно. Захиалагч байгууллага нь энэхүү үндэслэлээр тендерийн саналаас татгалзсан бөгөөд нийтийн гэрээний төсөвт өртөг нь олон улсын босго үнэтэй тэнцүү буюу түүнээс давсан тохиолдолд Сангийн ямаар дамжуулан Европын Комисст энэ тухай мэдэгдэнэ.

#### **§ 49. Бүх тендерийн саналаас татгалзах**

(1) Захиалагч байгууллага нь дараахи тохиолдолд бүх тендерийн саналаас татгалзсан тухай үндэслэл бүхий шийдвэр бичгээр гаргаж болно. Үүнд:

1) Тохиромжтой гэж зарлагдсан бүх тендерийн саналын өртөг нь нь нийтийн гэрээний төсөвт өртгөөс хэтэрсэн бол, эсхүл

2) Захиалагч байгууллага нь бүх тендерийн саналаас татгалзах боломж болон холбогдох бодитой бөгөөд үл ялгаварлах үндэслэлийг гэрээний баримт бичигт тусгасан бөгөөд тэрхүү үндэслэлийг биелүүлсэн бол.

(2) Захиалагч байгууллага нь нэг худалдан авах ажиллагааг хэд хэдэн багцад хуваасан бол дараахи тохиолдолд бүх тендерийн саналаас татгалзаж болно. Үүнд:

1) энэхүү багцад ирүүлсэн тендерийн саналуудад энэ хэсгийн 1-р дэд хэсэгт заасан үндэслэл байгаа бол;

2) эдгээр багцуудын тухайд нийтийн гэрээ байгуулах эрх олгох нь зохисгүй бөгөөд захиалагч байгууллагын тавьсан нийтийн худалдан авах ажиллагааны зорилгод нийцэхгүй байгаа бол. Тэрчлэн 29-р хэсгийн 3-р дэд хэсгийн 2-7-д заасан журмын дагуу худалдан авах ажиллагааг дуусгавар болгох үндэслэл байгаа бол.

#### **§ 50. Тендерийн саналыг үнэлэх ба тендер амжилттай явагдсаныг зарлах**

(1) Захиалагч байгууллага нь тохиромжтой гэж зарлагдсан тендерийн саналуудыг үнэлнэ. Захиалагч байгууллага нь тендерийн саналуудыг үнэлэхдээ зөвхөн гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичиг, эсхүл тендерийн урилгад заасан шалгуурыг харгалзан үзнэ.

(2) Захиалагч байгууллага нь эдийн засгийн хувьд хамгийн ашигтай тендерийн саналд үндэслэн нийтийн гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд гэрээний мэдэгдэл ба гэрээний баримт бичигт дурдсан нийтийн гэрээний объектод хамаарах үнэлгээний шалгуурт харгалзах харьцангуй ногдол хувийн дагуу үнэлгээ хийнэ.

(3) Захиалагч байгууллага нь тендерийн саналыг хамгийн бага өртөгт үндэслэн нийтийн гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тендерийн саналуудыг зөвхөн үнийн дүнгээр нь үнэлэх бөгөөд хамгийн бага өртөгтэй тендерийн саналыг амжилттай болсон талаар бичгээр мэдэгдэнэ.

(4) Захиалагч байгууллага нь нийтийн худалдан авалтыг нэг худалдан авах ажиллагааны хүрээнд олон багцад хуваасан тохиолдолд тендерийн саналыг багцаар нь үнэлж, амжилттай тендерийн саналыг мөн багцаар нь зарлана.

(5) Тендерийн саналд дурдсан нэгжийн үнэ нь нийтийн гэрээнд үндэслэн төлөх ёстой төлбөр бөгөөд тендерийн саналын өртөг ба нийт тооцолсон өртөг нь тендерийн саналд дурдсан нэгжийн үнэд үндэслэн тооцоолсон тооцоотой зөрсөн тооцооллын алдаа гарсан

тохиолдолд захиалагч байгууллага тооцооллын алдааг тендерийн саналд дурдсан нэгжийн үнэд үндэслэн засах ёстой бөгөөд энэ тухайгаа тендерт оролцогчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Тендерт оролцогч нь холбогдогдох мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор захиалагч байгууллагад тооцооллын алдааг засварласныг хүлээн зөвшөөрч байгаа эсэхээ бичгээр мэдэгдэнэ. Хэрэв тендерт оролцогч тооцооллын алдааг засварлахыг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч байгууллага уг тендерийн саналаас татгалзана.

### **§ 51. Цахим дуудлага худалдаа**

(1) Цахим дуудлага худалдаа нь захиалагч байгууллагын энэ хэсэгт заасан журмын дагуу цахим орчинд тендерийн нөхцлүүдийн тоон үзүүлэлтийг харьцуулж, үнэлэх замаар амжилттай тендерийн саналыг шалгаруулах тендерийн саналыг үнэлэх хамгийн эцсийн шат юм.

(2) Нээлттэй ба хязгаарлагдмал журмын хувьд, тэрчлэн энэхүү хуулийн 27-р хэсгийн 2-р дэд хэсгийн 1-р заалтад дурдсан гэрээний мэдэгдлийг урьдчилан нийтлэж тохиролцох журмын хувьд захиалагч байгууллага нь нийтийн гэрээний объектыг маш нарийн тодорхойлох нөхцөлтэйгөөр цахим дуудлага худалдаа зохион байгуулж болно. Тийм ч учраас цахим дуудлага худалдааг нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын төлөвлөлт гэх мэт объект нь оюуны үйл ажиллагаа байх үйлчилгээний гэрээ эсхүл нийтийн өмчийн барилга байгууламжийн ажлын гэрээ байгуулахад цахим дуудлага худалдаа зохион байгуулж болохгүй.

(3) Цахим дуудлага худалдааг ерөнхий гэрээний оролцогчид болох тендерт оролцогчдын дунд өрсөлдөөн зохион байгуулж нийтийн гэрээ байгуулах эрх олгох, мөн динамик худалдан авалтын системд хэрэглэж болно.

(4) Цахим дуудлага худалдаа нь дараахи зүйлд үндэслэнэ. Үүнд:

1) Захиалагч байгууллага нь хамгийн бага үнэтэй тендерийн саналд үндэслэн нийтийн гэрээ байгуулах олгож буй тохиолдолд зөвхөн тендерийн саналын өртгийг харгалзан үзнэ.

2) захиалагч байгууллага нь эдийн засгийн хувьд хамгийн ашигтай тендерийн саналд үндэслэн нийтийн гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тендерийн саналуудын үнэ буюу тендерийн саналын үнэлгээний бусад тоон шалгуурыг харгалзана.

(5) Захиалагч байгууллага нь цахим дуудлага худалдаа зохион байгуулах талаар гэрээний мэдэгдэлд дурдана.

(6) Захиалагч байгууллага эдийн засгийн хувьд хамгийн ашигтай тендерийн саналд үндэслэн нийтийн гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд цахим дуудлага худалдаа зохион байгуулахын өмнө тендерийн санал гэрээний баримт бичигт заасан нөхцлүүдийг хангаж байгаа эсэхийг нягталж, дуудлага худалдааг эхлүүлэхээс өмнө тендерийн саналуудын болон тэдгээрийн харьцангуй жинд тохирох шалгуураар тендерийн саналуудыг үнэлнэ.

(7) Хэрэглээний тоног төхөөрөмжийн цахим дуудлага худалдаа зохион байгуулах, явуулах журам зэрэгт тавигдах шаардлагыг Бүгд найрамдах улсын Засгийн газраар тогтооно.

(8) Бүгд найрамдах улсын Засгийн газар нь энэ хэсгийн 7-р дэд хэсэгт үндэслэн холбогдох шаардлагыг тодорхойлоогүй тохиолдолд цахим дуудлага худалдааны явцад 55-р хэсгийн 5-р дэд хэсэгт заасан аливаа шаардлага тендерийн санал ирүүлэхэд хамаарахгүй.

## **Дэд бүлэг 5**

### **Мэдэгдэл**

#### **§ 54. Тендерт оролцогчид ба өрсөлдөгчдөд шийдвэрийг мэдэгдэх**

(1) Захиалагч байгууллага тендерт оролцогчид буюу өрсөлдөгчдөд худалдан авах ажиллагааны хүрээнд тэдгээрийн эрх ба үүрэгт нөлөө үзүүлж болох аливаа шийдвэрийн талаар нэн даруй буюу ажлын 3 өдрөөс хэтрүүлэлгүйгээр бичгээр мэдэгдэнэ. Үүнд тендерийн үйл ажиллагаанаас тендерт оролцогч буюу өрсөлдөгчийг хассан тухай шийдвэр, тендерт оролцогч буюу өрсөлдөгч тендерт шалгуур хангасан буюу хангаагүй тухай шийдвэр, тендерийн бүх саналыг хүлээж аваагүй тухай шийдвэр, энэхүү хуулийн 65-р зүйлийн 4-р дэд хэсэгт тухай шийдвэр, тендерийн санал шаардлага хангасан тухай шийдвэр ба тендерийн санал амжилттай болсон тухай тендерт оролцогчид буюу өрсөлдөгчдийн нэрсийг дурдсан шийдвэр, хэнд болон хэний тендерийн саналын талаар холбогдох шийдвэр гарсан тухай, тэрчлэн нийтийн гэрээ болон ерөнхий гэрээ байгуулахаас татгалзсан шалтгаан, эсхүл худалдан авах ажиллагааг дахин эхлүүлэх болсон тухай зэрэг багтана.

(2) Тендерт оролцогч буюу өрсөлдөгчийн хүсэлтээр захиалагч байгууллага өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор дараахи зүйлсийг бичгээр мэдэгдэнэ. Үүнд:

1) Тендерт оролцогч буюу өрсөлдөгчийг шалгаруулаагүй шалтгаан;

2) тендерт оролцогчийн хувьд тендерийн саналаас татгалзсан шалтгаан, түүний дотор энэхүү хуулийн 33-р зүйлийн 2-р дэд хэсэгт заасны дагуу тендерийн санал тэгш бус

байхад гаргасан шийдвэрүүд, эсхүл 3-р дэд хэсэгт заасан гүйцэтгэл буюу үүрэг функцийн шаардлагуудыг хангаагүй бол;

3) тендерийн санал ирүүлсэн тендерт оролцогч бүрт амжилттай шалгарсан тендерийн санал болон түүний давуу талыг тэдний ирүүлсэн саналтай харьцуулан тодорхойлсон мэдээлэл болон тендерийн санал нь амжилттай болсон хэмээн зарлагдсан тендерт оролцогч буюу тендерт оролцогчдийн нэрсийн хамт илгээнэ.

(3) Захиалагч байгууллага 1-р дэд хэсэгт дурдсан мэдэгдлүүдийн талаархи мэдээллийг хэрэв тэрхүү мэдээллийг ил болгох нь хууль сахиулах байгууллагын ажилд саад учруулахаар бол, эсхүл нийтийн эрх ашигт харшлах буюу компанийн нууцыг задруулахаар бол, эсхүл тэдгээрийн харилцан өрсөлдөөнд хохирол учруулахаар байгаа бол тендерт оролцогчид буюу өрсөлдөгчид илгээхгүй байж болно.

(4) Захиалагч байгууллага энэхүү хэсгийг 1 ба 2-р дэд хэсэгт дурдсан мэдээллийг тендерт оролцогчид буюу өрсөлдөгчдөд цаг алдалгүй, гэхдээ тендер амжилттай болсныг зарлах шийдвэр эсхүл худалдан авах ажиллагааг дуусгавар болгох шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор илгээх замаар энэхүү хэсгийг 1 ба 2-р дэд хэсэгт дурдсан нөхцлүүдээс зайлсхийж болно.

#### **§ 55. Харилцаа холбоо болон баримт бичгийн маягтад тавигдах шаардлагад мөрдөх журам**

(1) Энэхүү бүлэгт дурдсан бүх харилцаа холбоо, мэдээллийн солилцоог энэхүү бүлэгт өөрөөр заагаагүй тохиолдолд шуудан, факс, эсхүл биечлэн хүргэх, эсхүл цахим шуудангаар явуулна. Захиалагч байгууллагаас энэхүү бүлэгт дурдсан нөхцлүүдэд үндэслэн ирүүлсэн аливаа мэдэгдэл, мэдээллийг тэрхүү мэдэгдлийг холбогдох нөхцлийн хүрээнд шаардлагатай хэмээн илгээсэн тохиолдолд хугацаанд нь ирүүлсэн гэж тооцно.

(2) Захиалагч байгууллагын ашиглаж буй харилцаа холбооны хэрэгсэл болон цахим мэдээлэл нь нийтэд олдоцтой бөгөөд нийтэд ашиглагдаж байгаа мэдээлэл, харилцаа холбооны технологитой зохицон ажиллах боломжтой, ингэснээрээ сонирхогчдын худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг шалтгаангүйгээр хязгаарлахгүй байх ёстой.

(3) Харилцаа холбоо ба мэдээллийг солилцох ба хадгалахдаа өгөгдлүүдийн бүрэн бүтэн байдал, тендерийн санал, худалдан авах ажиллагааанд оролцох хүсэлт болон бусад баримт бичгийн нууцлалыг хангах ёстой бөгөөд захиалагч байгууллага тендерийн санал ба

худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг зөвхөн тэдгээрийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш онгойлгох буюу шалгаж болно.

(4) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг цахим хэлбэрээр ирүүлэхэд шаардлагатай мэдээлэл ба техникийн шаардлагууд, түүнчлэн шифрлэлтийн талаар бүх сонирхогч этгээдэд мэдээлнэ.

(5) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг цахим хэлбэрээр ирүүлэхэд дор хаяж дараахь шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1) Цахим гарын үсэг нь Тоон гарын үсгийн тухай хууль болон Европынг холбооны гишүүн орнуудын цахим гарын үсэгтэй холбоотой бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан байх ёстой. (OJ L 13, 19 January 2000, pgs 12-20);

2) Захиалагч байгууллага тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг хүлээн авах нарийвчилсан хугацааг тогтоож болно;

3) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг хүлээлгэн өгөхөөс өмнө тэдгээрийг илгээгч этгээдээс бусад этгээд тэдгээр баримт бичигт нэвтрэх боломжгүй байх ёстой;

4) Энэхүү дэд хэсгийн 3-т заасан нэвтрэх боломжгүй байх заалт зөрчигдсөн тохиолдолд энэ тухай тодорхой мэдэгдэнэ;

5) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг нээх хугацааг зөвхөн захиалагч байгууллагаас томилогдсон этгээд тогтоох буюу өөрчилнө;

6) Худалдан авах ажиллагааны туршид захиалагч байгууллагаас томилогдсон этгээд нь тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтэд зөвхөн зэрэгцэн явагдаж буй ажиллагаанаас үүдэн захиалагч байгууллагын тогтоосон өдөрт нэвтэрч болно;

7) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтэд дурдсан мэдээлэлд зөвхөн захиалагч байгууллагаас томилогдсон этгээд нэвтэрч болно.

(6) Тендерийн санал ба худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг цахим хэлбэрээр ирүүлэхэд тавигдах шаардлагыг Бүгд найрамдах улсын Засгийн газар тогтооно.

## **§56. Тайлбар**

(1) Тухайн мөчид худалдан авах ажиллагаанд оролцох боломжтой худалдан авах ажиллагаанд оролцогч болон сонирхогч этгээд бүр гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичиг болон тендерийн урилгын талаар тайлбар, нэмэлт мэдээлэл хүлээн авах эрхтэй.

(2) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэл, гэрээний баримт бичиг болон тендерийн урилгын талаар тайлбар, нэмэлт мэдээллийг хэвлүүлэх боломжтой гэж үзвэл тэдгээрийг хүсэлт гаргасан этгээд болон гэрээний баримт бичиг буюу тендерийн саналын урилгыг хүлээн авсан тендерт оролцогчид ба өрсөлдөгчид, эсхүл тухайн мөчид худалдан авах ажиллагаанд оролцох боломжтой нь гэрээний баримт бичигт тодорхой болсон гэрээний баримт бичгийг хүлээн авагч сонирхогч этгээд нарт нэгэн зэрэг илгээж болно. Захиалагч байгууллага тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 ажлын өдрийн дотор дурдсан мэдээллийг гаргаж өгнө.

(3) Захиалагч байгууллага тендерт оролцогч буюу өрсөлдөгчөөс энэхүү хуулийн 39-р зүйлийн 4-р дэд хэсэгт дурдсан тендерийн санал буюу тайлбар, мэдээлэл буюу баримт бичигт дурдагдсан мэдээллийг тайлбарлах, нарийвчлах буюу тодруулахыг шаардаж болно. Тендерт оролцогч буюу өрсөлдөгч холбогдох хүсэлтийг хүлээн авнаас хойш 3 ажлын өдрийн дотор тэдгээрийг ирүүлэх үүрэгтэй.

## **Бүлэг 6**

### **Нээлттэй журам**

#### **§ 57. Нээлттэй журмаар гэрээний баримт бичгийг хүргүүлэх**

(1) Нээлттэй журмын хувьд захиалагч байгууллага сонирхогч бүх этгээдэд гэрээний мэдэгдэл заасны дагуу гэрээний баримт бичгийг байрлаж буй газраас нь буюу цахим хуудаснаас авах боломжийг хангана. Түүнчлэн захиалагч байгууллага гэрээний баримт бичгийг бичгэн хэлбэрээр болон цахим шуудангаар цахим хэлбэрээр хүргүүлж болно. Захиалагч байгууллага гэрээний баримт бичгийг авсан бүх этгээдийг бүртгэж авах ёстой. Хэрэв захиалагч байгууллага гэрээний баримт бичгийг цахим хуудаснаас авах боломж олгож байгаа бол сонирхогч этгээд уг цахим хуудсан дээр гэрээний баримт бичгийг хүлээж авсан этгээд болохоо өөрөө бүртгүүлж, захиалагч байгууллагад холбогдох мэдээллээ үлдээх боломжтой байх ёстой.

(2) Захиалагч байгууллага тендерийн санал ирүүлэх хугацааг нийтийн гэрээний объект, юун түүрүүнд түүний онцлог ба тоо ширхэг, эзлэхүүн буюу хэмжээ зэргийг болон энэхүү хуулийн 35-р зүйлд заасан хамгийн бага хугацааг харгалзан тогтооно.

(3) Захиалагч байгууллага гэрээний баримт бичгийг аливаа хязгаарлалтгүйгээр, бүрэн дүүрэн хэлбэрээр цахим байдлаар авах боломжоор хангаж чадахгүй тохиолдолд холбогдох



хүсэлтийг хүлээн авснаас хойш 3 ажлын өдрийн дотор гэрээний баримт бичгийг сонирхогч этгээдэд илгээнэ.

### **§58. Нээлттэй журмаар тендерийн саналыг ирүүлэх, нээх ба үнэлэх**

(1) Нээлттэй журмын хувьд сонирхогч бүх этгээд тендерийн санал ирүүлж болно.

Тендерийн саналтай хамт тендерт оролцогчийн гэрээний мэдэгдэлд дурдсан шаардлагыг хангах чадварыг нотолсон баримт бичгийг ирүүлнэ.

(2) Захиалагч байгууллага бүх тендерийн саналыг тогтоосон хугацаанд нээж, энэхүү хууль болон гэрээний мэдэгдэлд заасны дагуу бүх тендерт оролцогчдын шаардлага хангасан эсэх болон шалгарсан тендерт оролцогчдын тендерийн санал гэрээний мэдэгдэл болон гэрээний баримт бичгийн нөхцлүүдтэй нийцэж байгаа эсэхийг магадлаж, энэхүү хуульд заасан худалдан авах ажиллагааны шаардлагад нийцсэн хэмээн зарлагдсан тендерийн саналыг үнэлнэ.

(3) Худалдан авах ажиллагааны туршид захиалагч байгууллага яриа хэлэлцээ хийхгүй байж болно.

## **Бүлэг 7**

### **Хязгаарлагдмал журам**

#### **§59. Хязгаарлагдмал журам дахь тендерт өрсөлдөгчид**

(1) Хязгаарлагдмал журмын тухайд сонирхогч бүх этгээд худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ гэрээний мэдэгдэлд заасан шалгуурыг хангаж буйгаа нотолсон бичиг баримтын хамтаар ирүүлнэ. Худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтийг энэхүү хууль болон түүнд үндэслэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн бичгээр буюу цахим хэлбэрээр ирүүлнэ. Захиалагч байгууллага тэрхүү хүсэлтийг хүлээн авсан тухай нотолгоог тендерт өрсөлдөгчийн хүсэлтээр нэн даруй илгээнэ.

(2) Гэрээний мэдэгдэлд тендерийн урилга илгээх этгээдэд тоон хязгаарлалт тавих замаар захиалагч байгууллага худалдан авах ажиллагаанд оролцох өрсөлдөгчдийн тоог гэрээний мэдэгдлээр хязгаарлаж болно. Уг тоо нь дор хаяж 5 байж болох бөгөөд шаардлагатай бол тооны дээд хязгаар болон өрсөлдөгчдийг сонгох бодит болон үл ялгаварлах шаардлагуудыг тавьж болно.

(3) Захиалагч байгууллага худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ ирүүлсэн бүх өрсөлдөгчдийн шаардлага хангаж буй эсэхийг энэхүү хуульд болон гэрээний мэдэгдэлд заасан нөхцлийн магадлан шалгана.

## **§60. Хязгаарлагдмал журмаар тендерийн урилга илгээх**

(1) Захиалагч байгууллага тендерийн урилгыг шаардлага хангасан бүх өрсөлдөгчдөд буюу §59 (2)-т заасны дагуу гэрээний мэдэгдэлд хязгаарлагдмал тооны өрсөлдөгчтэй байхаар заасан бол дор хаяж зохих тооны шаардлага хангасан өрсөлдөгчдөд нэгэн зэрэг илгээнэ.

(2) Шаардлага хангасан өрсөлдөгчдийн тоо гэрээний мэдэгдэлд заасан өрсөлдөгчдийн тооны доод хязгаарт хүрэхгүй байгаа тохиолдолд захиалагч байгууллага тендерийн урилгыг шаардлага хангасан бүх өрсөлдөгчдөд илгээх замаар худалдан авах ажиллагааг үргэлжлүүлж болно.

(3) Захиалагч байгууллага бүртгэлд нийтлэгдсэн гэрээний баримт бичиг болон гэрээний мэдэгдлийн лавлагааг цахим хэлбэрээр аливаа хязгаарлалтгүй, бүрэн дүүрэн авах нөхцлийг хангасан тохиолдолд гэрээний баримт бичгийг тендерийн урилгын хамт вэб хаягт байршуулна.

## **§61. Хязгаарлагдмал журмаар тендерийн саналыг нээх ба үнэлэх**

(1) Захиалагч байгууллага нь тендерийн бүх саналыг нээж, тэдгээр нь гэрээний мэдэгдэлд дурдсан нөхцлийг хангаж байгаа эсэхийг шалгаж, энэхүү бүлэгт заасан худалдан авах ажиллагаанд тохиромжтой хэмээн зарлагдсан бүх тендерийн саналд үнэлэлт өгнө.

(2) Захиалагч байгууллага худалдан авах ажиллагааны явцад яриа хэлэлцээ явуулахгүй байж болно.

## **Бүлэг 8**

### **Өрсөлдөөнт хэлцэл**

## **§62. Өрсөлдөөнт хэлцлийн өрсөлдөгчид**

(1) Өрсөлдөөнт хэлцлийн үед сонирхогч этгээд бүр худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ өрсөлдөгчийн гэрээний мэдэгдэлд дурдсан шаардлагыг хангасан болохыг нотолсон баримт бичгийн хамтаар ирүүлж болно. Худалдан авах ажиллагаанд оролцох хүсэлтээ энэхүү хуульд болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид нийцүүлэн бичгээр буюу цахим хэлбэрээр ирүүлнэ. Захиалагч байгууллага тэрхүү хүсэлтийг хүлээн авсан тухай нотолгоог тендерт өрсөлдөгчийн хүсэлтээр нэн даруй илгээнэ.

(2) Захиалагч байгууллага худалдан авах ажиллагаанд оролцох, түүнтэй хэлцэл хийж буй өрсөлдөгчдийн тоонд хязгаарлалт тавих замаар худалдан авах ажиллагаанд оролцох өрсөлдөгчдийн тоог хязгаарлаж болно. Уг тоо нь дор хаяж 3 байж болох бөгөөд тооны

дээд хязгаар, зорилго болон өрсөлдөгчдийг сонгох үл ялгаварлах шалгуууудыг тавьж болно.

(3) Захиалагч байгууллага бүх өрсөлдөгчдийн шаардлага хангаж буй эсэхийг энэхүү хуульд болон гэрээний мэдэгдэлд заасан нөхцлийн дагуу магадлан шалгана.

### **§63. Хэлцэл**

(1) Захиалагч байгууллага шаардлага хангасан бүх өрсөлдөгчид, эсхүл энэхүү хуулийн §62

(2)-т заасны дагуу худалдан авах ажиллагааны мэдэгдэлд өрсөлдөгчдийн тоог хязгаарласан бол дор хаяж зохих тооны өрсөлдөгчдөд нэгэн зэрэг, захиалагч байгууллагын хэрэгцээг хамгийн сайн хангаж чадахуйц шийдлийг олохын тулд, бичгээр ахин гаргах боломжтой хэлбэрээр хэлцэл эхлүүлэх саналыг хүргүүлнэ.

(2) Шаардлага хангасан өрсөлдөгчдийн тоо гэрээний мэдэгдэлд заасан өрсөлдөгчдийн тооны доод хязгаараас цөөн байгаа тохиолдолд захиалагч байгууллага шаардлага хангасан бүх өрсөлдөгчдөд хэлцэл эхлүүлэх санал илгээх замаар худалдан авах ажиллагааг үргэлжлүүлж болно.

(3) Энэхүү хэсгийн 1-р дэд хэсэгт заасан хэлцлийг эхлүүлэх саналд дараахи зүйлсийг багтаасан байна. Үүнд:

1) нийтийн гэрээний объектын тодорхойлолт, эсхүл захиалагч байгууллага тодорхойлолтыг цахим хэлбэрээр аливаа хязгаарлалтгүй авах боломжийг хангаж байгаа тохиолдолд вэб хуудасны лавлагаа;

2) гэрээний мэдэгдэл нийтлэгдсэн тухай лавлагаа;

3) хэлцлийг эхлүүлэх цаг хугацаа ба газар, ашиглагдах хэл ба хэлнүүд;

4) захиалагч байгууллага хэлцлийн явцад санал болгосон шийдлүүдийн оюуны болон бусад эзэмших эрхийг шилжүүлэхийг шаардах эсэх, санал болгож буй шийдлүүд нь хэлцэлд оролцож буй бусад этгээд ашиглах боломжтой эсэх, тендерийн эцсийн саналыг захиалагч байгууллагын сонгосон нэг шийдэл дээр үндэслэн ирүүлсэн эсэх, эсхүл хэлцлийн явцад өрсөлдөгчийн гаргасан шийдлийн санал бүрд үндэслэсэн эсэх;

5) хэлцлийн явцад шийдлийг боловсруулахтай холбогдон гарсан зардлыг нөхөн олгохоор тохиолдолд, эсхүл оролцох хураамжийн хувьд түүний хэмжээ, төлбөрийн нөхцөл болон журам.

(4) Захиалагч байгууллага энэхүү хэсгийн 1-р дэд хэсэгт заасан саналыг гаргахад өрсөлдөөнт хэлцлийн онцлогоос шалтгаалж тодорхойлох боломжгүй эсхүл хэлцлийн

явцад хэлэцээ хийгдэж байгаа мэдээллийг нийтийн гэрээний объектын тодорхойлолтод оруулахгүй.

(5) Захиалагч байгууллага хэлцлийн явцад хэлцэлд оролцогч бүх өрсөлдөгчдөд тэгш хандах ёстой. Захиалагч байгууллага нь мэдээллийг ялгаварлах байдлаар дамжуулах ёсгүй бөгөөд хэлцлийн явцад өрсөлдөгчдийн ирүүлсэн шийдлүүд болон бусад итгэмжит мэдээллийг хэлцэлд оролцогч бусад өрсөлдөгчдөд болон бусад гуравдагч этгээдэд дамжуулах ёсгүй.

(6) Захиалагч байгууллага гэрээний мэдэгдэлд тийнхүү заасан бол хэлцлийг хэд хэдэн үе шаттайгаар, үе шат бүрт хэлэлцэх шийдлүүдийн тоог бууруулах замаар явуулж болно. Тохиромжтой шийдлүүд байгаа тохиолдолд сүүлчийн шатанд хэлэлцэгдэх шийдлүүдийн тоон нь өрсөлдөөнийг хангахуйц хэмжээтэй байна.

(7) Хэлцлийн явцад цаашид байгуулагдах нийтийн гэрээ бүх нөхцлийг хэлэлцэж болно.

(8) Захиалагч байгууллага нь хэрэгцээндээ хамгийн нийцсэн шийдэл болох хүртэл өрсөлдөгчидтэй хийх хэлцлийг явуулж болно.

(9) хэлцлийн явцад хүрсэн шийдлүүдийг захиалагч байгууллага ба өрсөлдөгчийн гарын үсэг зурсан протоколд тэмдэглэнэ.

(10) Захиалагч байгууллага тендерт оролцогчдод урамшуулал олгох буюу хэлцлийн явцад шийдлийг олохын тулд гарсан зардлын тодорхой хувийг нөхөн олгож болох бөгөөд тэдгээрийн хэмжээг санал болгосон шийдлийн тохиромжтой байдлын нөхцлөөс шалтгаалан ялгаатай байж болно.

#### **§64. Тендерийн урилгыг илгээх ба өрсөлдөөнт хэлцлийн үед тендерийн саналыг үнэлэх**

(1) Захиалагч байгууллага өөрийн хэрэгцээнд хамгийн тохиромжтой шийдлүүдийн тодорхойлтын дагуу хэлцэлд оролцож буй бүх өрсөлдөгчдөд хэлцэлд орлцож байгаа бүх өрсөлдөгчдөд хэлцлийг дуусгах талаар мэдэгдэх ёстой бөгөөд түүний зэрэгцээ тэдэнд хэлцлийн явцад тодорхойлж танилцуулсан шийдлүүдэд үндэслэсэн тендерийн урилгыг илгээнэ. Тендерийн урилга нь энэхүү хуулийн 31-р зүйлийн 2-т заасан тендерийн санал ирүүлэхэд болон худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд гэрээний мэдэгдэлд дурдаагүй мэдээллийг багтаах ёстой. Энэхүү хууль болон түүнд үндэслэн гаргасан хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу тендерийн урилгыг бичгээр буюу цахим хэлбэрээр илгээнэ.